47. Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Жудагийн Баярмаа, Дуламын Бум-Очир, Жанчивын Галбадрах, Даваасамбуугийн Ганмаа, Батбаярын Жаргалан, Жаргалсайханы Золжаргал, Б.Мөнхсоёл гишүүн, А.Ундраа гишүүн, Б.Пунсалмаа гишүүн, О.Саранчулуун гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Эрүүл мэндийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “32.1.2 Чихрийн шижин өвчний тархалт буурч, хүн амын дунд эрүүл хооллолт, хөдөлгөөний идэвх нэмэгдэнэ.” гэсэн дэд заалт, “32.1.2.1 Архаг эмгэгийн дундаас чихрийн шижингийн тархалтыг бууруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-5%” гэсэн дэд заалт, “32.1.3 Тамхины хэрэглээ буурч, уушги, зүрх судасны өвчний шалтгаант нас баралт, өвчлөл буурна.” гэсэн дэд заалт, “32.1.3.1 Өдөр бүр тамхи татдаг хүмүүсийн эзлэх хувийг бууруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-5%” гэсэн дэд заалт, “32.1.4 Архи, согтууруулах ундааны хэрэглээний бууралтаар эрүүл мэндийн хохирол, осол гэмтэл, нийгмийн сөрөг нөлөө буурна.” гэсэн дэд заалт, “32.1.4.1 Нэг хүнд ногдох архины хэрэглээг бууруулах. Хэмжих нэгж: Литр, Суурь он: 2024, Суурь түвшин: 21.9, Зорилтот түвшин: 21” гэсэн дэд заалт, “32.1.5 Эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөн төлөвшин, таргалалт, зүрх судас болон чихрийн шижингийн эрсдэл буурна.” гэсэн дэд заалт, “32.1.5.1 Таргалалтын түвшинг бууруулах (Биеийн жингийн индекс ≥ 30). Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-5%” гэсэн дэд заалт, “32.1.6 Чихрийн шижингийн эрт илрүүлэлт, оношлогоо, хяналт сайжирч, хүн амын дунд өвчлөлийг бууруулах нөхцөл бүрдэнэ.” гэсэн дэд заалт, “32.1.6.1 Артерийн даралт 140/90 мм.муб-аас дээш, цусан дахь глюкозыг нь хэмжсэн хүмүүсийн дунд чихрийн шижингийн илрүүлэлтийн түвшинг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “32.2.6 Хорт хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналтын үр дүн дээшлүүлэх” гэсэн дэд заалт, “32.2.6.1 Хорт хавдраар оношлогдож, эмчлэгдсэнээс хойш 5-аас дээш жил амьдарсан иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 42.7, Зорилтот түвшин: 45.0” гэсэн дэд заалт, “32.4.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоонд анхан шатны тусламж, урьдчилан сэргийлэх үйлчилгээний үүрэг, санхүүжилт нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийн чанар, хүртээмжийг сайжруулах” гэсэн дэд заалт, “32.4.2.1 Эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээнд зарцуулж буй нийт зардалд анхан шатны тусламж, үйлчилгээний зарцуулалтын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “32.4.3 Эрүүл мэндийн даатгалын хамралт өргөжиж, шимтгэлээ өөрөө төлөгч иргэдийн тоо нэмэгдэж, даатгалын сангийн тогтвортой байдал, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.” гэсэн дэд заалт, “32.4.3.1

Шимтгэлээ өөрөө хариуцдаг иргэдийн хамралтыг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “32.4.4 Иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн дарамт буурч, санхүүгийн хамгаалалт сайжирна.” гэсэн дэд заалт, “32.4.4.1 Эрүүл мэндийн урсгал зардалд иргэдийн хувиасаа хийж буй төлбөрийн хувь хэмжээг бууруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14

78.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

48.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Жудагийн Баярмаа, Дуламын Бум-Очир, Жанчивын Галбадрах, Даваасамбуугийн Ганмаа, Батбаярын Жаргалан, Жаргалсайханы Золжаргал, Б.Мөнхсоёл гишүүн, А.Ундраа гишүүн, Б.Пунсалмаа гишүүн, О.Саранчулуун гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Эрчим хүчний сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 33.1.2.1 дэх дэд заалтын “км” гэснийг, Хэмжих нэгж: "МВт" гэх, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14

78.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

49.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Жудагийн Баярмаа, Дуламын Бум-Очир, Жанчивын Галбадрах, Даваасамбуугийн Ганмаа, Батбаярын Жаргалан, Жаргалсайханы Золжаргал, Б.Мөнхсоёл гишүүн, А.Ундраа гишүүн, Б.Пунсалмаа гишүүн, О.Саранчулуун гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Эрчим хүчний сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “33.1.5.2 Хот суурин газрын агаарын бохирдлын бууралт, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-5%” гэсэн дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14

78.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

50.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Жудагийн Баярмаа, Дуламын Бум-Очир, Жанчивын Галбадрах,

Даваасамбуугийн Ганмаа, Батбаярын Жаргалан, Жаргалсайханы Золжаргал, Б.Мөнхсоёл гишүүн, А.Ундраа гишүүн, Б.Пунсалмаа гишүүн, О.Саранчулуун гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 34.1.3.1 “Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээ” гэснийг “Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 83.6%, Зорилтот түвшин: 85%” гэж, 34.1.4.1 “Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам сүлжээ” гэснийг “Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 69.6%, Зорилтот түвшин: 70%” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 14

71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

51. Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Жудагийн Баярмаа, Дуламын Бум-Очир, Жанчивын Галбадрах, Даваасамбуугийн Ганмаа, Батбаярын Жаргалан, Жаргалсайханы Золжаргал, Б.Мөнхсоёл гишүүн, А.Ундраа гишүүн, Б.Пунсалмаа гишүүн, О.Саранчулуун гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “34.1.5.3 Түрээсийн орон сууцанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “34.1.5.4 Түрээсийн орон сууцанд хамрагдсан өрхийн хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “34.1.1.2 Барилгын зураг төслийн магадлан, барилгын ажлын улсын комисст зарцуулах голч хугацаа буурах хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “34.1.1.3 Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ шинээр авч буй барилгад эзлэх ногоон барилгын шалгуур хангасан барилгын эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 1, Зорилтот түвшин: 10” гэсэн дэд заалт, “34.1.1.4 Олон нийтийн барилгын орц гарцыг түгээмэл загвараар шийдсэн барилгын хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 11, Зорилтот түвшин: 21” гэсэн дэд заалт, “34.1.5.5 70%-аас дээш эрчим хүчний хэмнэлттэй болгон дулаалсан сууцны нийт сууцанд эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 7, Зорилтот түвшин: 17” гэсэн дэд заалт, “34.3.5.4 Нийт барилга байгууламжийн дундах галын дохиололтой барилгын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 3

Бүгд: 14
78.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

52. Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Жудагийн Баярмаа, Дуламын Бум-Очир, Жанчивын Галбадрах, Даваасамбуугийн Ганмаа, Батбаярын Жаргалан, Жаргалсайханы Золжаргал, Б.Мөнхсоёл гишүүн, А.Ундраа гишүүн, Б.Пунсалмаа гишүүн, О.Саранчулуун гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “35.1.1.2 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн нийт экспортод эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+1%” гэсэн дэд заалт, “35.1.1.3 Үндэсний агуулгатай уран бүтээлийн тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 2500, Зорилтот түвшин: 2550” гэсэн дэд заалт, “35.1.1.4 Авран хамгаалсан соёлын биет өвийн тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 15, Зорилтот түвшин: 30” гэсэн дэд заалт, “35.1.1.5 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 10924, Зорилтот түвшин: 10974” гэсэн дэд заалт тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 16 минут үргэлжилж, 24 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
11 цаг 25 минут

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Улсын Их Хурлын гишүүддээ өнөөдрийн өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Өнөөдөр Байнгын хорооны нийт 24 гишүүнээс 13 гишүүн ирснээр хуралдаан эхэлж байна.

Жамбын Батсуурь гишүүн ирсэн байна, Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн ирсэн, Мягмардашийн Сарнай гишүүн ирсэн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн ирсэн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн, Чинбатын Ундрам гишүүн ирсэн, Хажекберийн Жангабыл гишүүн ирсэн, Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн ирсэн, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирсэн, Одсүрэнгийн Номинчимэг нар ирээд байна.

Далайн Батбаяр гишүүн өвчний чөлөөтэй, Батмөнхийн Батцэцэг гишүүн өвчний чөлөөтэй, Жанчивын Галбадрах гишүүн гадаад томилолттой, Сонгобайн Замира гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Жаргалсайханы Золжаргал гишүүн гадаад томилолттой байна.

Ер нь Өргөдлийн байнгын хороо байгуулагдсанаас хойш өнөөдөр 4 дэх хуралдаанаа хийх гэж байна.

Манай Байнгын хороо 24 гишүүнтэй. Өнөөдөр өглөө 09.00 цагаас хурлаа зарласан боловч 2 цаг 30 минут хоцорч 11 цаг 30 минут хавьцаа эхэлж байна.

Бусад цагтаа ирсэн гишүүдээ 2 цаг 30 минут хүлээлгэж эмнэлгийн чөлөө болон бусад чөлөөгүйгээр орж ирэхгүй байгаа гишүүдэд анхааруулмаар байна. Бат-Эрдэнийн Бат-Өлзий гишүүн бас чөлөө авсан байгаа. Тийм ээ.

Байнгын хороо 4 удаа хуралдахад ер нь манай Байнгын хорооны гишүүдээс 3 гишүүн нэг ч удаа Байнгын хорооны хуралдаандаа суугаагүй. Ямар нэгэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр суугаагүй байна. Энэ 3 гишүүн бол Халтмаагийн Баттулга гишүүн, Хассуурийн Ганхуяг гишүүн, Саруулсайханы Цэнгүүн гишүүн нар байна.

Одоо энэ гишүүд маань нэгэнт Өргөдлийн байнгын хороонд хуваарилагдсан бол эрх, үүргийнхээ дагуу хуралдаа оролцож байх ёстой. Хэрвээ үнэхээр ямар нэгэн чөлөөтэй, гадаад томилолттой байх юм бол тэрийгээ хэлж байх ёстой.

Саруулсайханы Цэнгүүн гишүүний хувьд эхний 2 хуралдаан дээр гадаад томилолттой байсан юм байна. Хассуурийн Ганхуяг гишүүн уг нь өрөөндөө байгаад байдаг. Ирцдээ орохгүй ээ гэсэн хариу өгөөд байдаг.

Х.Ганхуяг гишүүн энэ Өргөдлийн байнгын хорооноос гарах өргөдлөө өгсөн боловч албан ёсоор Улсын Их Хурлаар шийдэгдээгүй байгаа учраас Та албан ёсоор энэ Байнгын хорооны гишүүн. Ирцдээ орж энэ хуралдаанд оролцох үүрэгтэй шүү гэдгийг хэлмээр байна. Энэ адилхан үгийг Халтмаагийн Баттулга гишүүнд хэлмээр байна.

Адилхан гишүүн болоод гишүүний эрх үүргийг эдлээд явж байгаа хүний хувьд үүнийг сануулж хэлэх нь зүйтэй гэж бодлоо.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр нэг асуудал хэлэлцүүлнэ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд буюу Засгийн газраас 2025 оны 9 сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн төсвийн гурав дахь хэлэлцүүлэг.

Санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлэхээр Өргөдлийн байнгын хороо өнөөдөр хэлэлцэх асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
гурав дахь хэлэлцүүлэг,
Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ажлын хэсэгт Сандагийн Бямбацогт сайд. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сайдыг дуудаарай. Танилцуулгыг хийхээр байгаа.

Т.Аубакир сайд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, П.Наранбаяр сайд гэж байна. Байгаа юм уу? Ажлын хэсгийн надад ирсэн, оролцож байгаа гэсэн хүмүүсийгээ ажлын албанаас дуудмаар байна.

Ж.Чинбүрэн сайд 9-өөс гээд тэгж байсан. Өөрөө хэлж байсан. Арга хэмжээтэй болоод явсан. П.Наранбаяр сайдыг дуудъя. Ирсэн байна гэдгээр орсон байна. Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч З.Цэдэнжав.

Энэ ажлын хэсгийнхнийг дуудаарай.

Ж.Чинбүрэн сайд, Эрүүл мэндийн сайд оролцож байна. Монгол Улсын ерөнхий аудиторовн орлогч З.Цэдэнжав, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү.

Ажлын хэсгээ тэгвэл дуудъя л даа. Төрийн байгуулалт чинь нэлээн түрүүн эхэлсэн байх аа. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат байхгүй байна. Ажлын хэсгийг дуудъя.

Манай Өргөдлийн байнгын хороо дээр иргэдээс ирж байгаа өргөдөл, гомдлын хүрээнд, ялангуяа бидний хэлэлцсэн эмч, багш нарын цалин, ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэхтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналууд гарсан.

Мөн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдэд яг энэ төсөв чинь үр дүнгээ өгдөг байхад бид ямар шалгуур үзүүлэлттэй байх юм бэ гэдэг талаар нэлээн олон санал гарсан байгаа.

Тэгээд энэ дээр холбогдох сайд нар болон төрийн нарийнууд, ялангуяа Сангийн яам, мэргэжлийн байгууллагууд нь оролцох ёстой шүү. Энэ дээр сайн хэлэлцэж байж санал хураалт явах саналууд байгаа учраас.

Д.Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ирсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар ирсэн байна. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг ирсэн байна. Боловсролын Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батжаргал ирсэн байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул ирсэн байна. Зэвсэгт хүчний жанжин штабын дарга С.Ганбямба ирсэн байна. Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал Ц.Наранчимэг ирсэн байна. Үндэсний Аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Энхболд ирсэн байна. Үндэсний Аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал Б.Баттуяа ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан.

Эдийн засаг, хөгжлийн яамныхан орж ирээгүй байна уу? Дуудаарай.

Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан. Дуудаарай. Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр дуудаарай. Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Төрийн байгуулалт дээр байна уу? Дуудаарай. Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо орж ирээгүй байна уу? Дуудаарай. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга ирсэн байна. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал.

Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа ирсэн байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа ирсэн байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын бодлогын газрын дарга

В.Рэнцэнханд ирсэн байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг ирсэн байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал ирсэн байна. Зам, тээврийн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Ч.Ундрэм сайд өөрөө манай Байнгын хорооны гишүүн. Бас оролцож байгаа гэдгийг хэлье.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Салбарын хяналтын газрын дарга Ч.Энх-Амгалан, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын дарга Б.Цэцэгсайхан, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга Н.Эрдэнэбаяр, Эрүүл мэндийн яамны Тусламж, үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга Б.Ууганбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань.

Эдийн засгийн хөгжлийн яамныхыг дуудаарай. Тийм ээ. Ядаж төлөөлөөд гол асуудлуудыг нь ярилцах, тэр урсгал зардал сайдын багцтай холбоотой саналууд байгаа учраас энэ дээр нь хариулт, тайлбар өгөх хүнийг нь дуудаарай. Салбарын нарийн юм бол манай дээр бол нэг их яригдахгүй учраас.

Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Урьболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ ирсэн байна. Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Сангийн яамны Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ, Сангийн яамны Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Б.Ганзориг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Даваасүрэн ирсэн байна. Боловсролын яамны Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адьяасүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга А.Амгаланзаяа ирсэн байна.

Монгол Улсын сайд Засгийн газар Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт сайд бас ирсэн байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн талаарх танилцуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2026 онд төсвийн төслийг боловсруулж, 2025 оны 9 сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Ирэх 2026 оны төсвийн төслийг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсрууллаа.

Төсвийн төсөлд туссан тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах онцлох арга хэмжээг дурдвал:

▷ **Нэгдүгээрт**, төсвийн урсгал зардлын хувьд удирдах албан тушаалтны орон тоог бууруулж, төрийн албан хаагчдын нийт орон тооны тэлэлтийг хязгаарлахын зэрэгцээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн байгууллага үр ашиггүй зардлыг бууруулан хэмнэгдсэн хөрөнгийг нийгмийн салбарт зарцуулах, экспортыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн арга хэмжээний зардлыг төсөвт тусгалаа.

▪ Энэ хүрээнд:

- ▶ геологийн судалгаа,
- ▶ эрлийн ажлын зардал,
- ▶ хүн амын хүнсний хэрэглээний улаан буудайн нөөц бүрдүүлэх зардал,
- ▶ байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал,
- ▶ гамшиг ослын үед бэлэн байдлыг хангах албан хаагчдын орлогын баталгааг сайжруулах шаардлагатай зардлыг

2026 оны төсвийн төсөлд тусган тооцлоо.

▷ **Хоёрдугаарт**, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн иргэдээс санал авч, сум, дүүрэг, аймаг, нийслэл, салбар яамдын түвшинд үе шаттайгаар төлөвлөсөн.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр нийт 14.4 их наяд төгрөгийн санхүүжих дүн бүхий 1700 төслийн санал хүлээн авснаас холбогдох шалгуур үзүүлэлт, зарчим, бодлогыг харгалзан эрэмбэлж 579 төсөл, арга хэмжээнд 3 их наяд 267 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан болно.

Нийт хөрөнгө оруулалтын 67 хувь буюу 2 их наяд 181 тэрбум төгрөг нь үргэлжлэн хэрэгжих бол 33 хувь буюу 1 их наяд 85 тэрбум төгрөг нь шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт байна.

Энэ нь 2022-2023 онд батлагдсан төсвийн тоотой харьцуулахад хоёр дахин буурсан үзүүлэлт бөгөөд төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлтийн чанар сайжирч байгааг илтгэж байна.

Түүнчлэн 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтад хүний хөгжлийг дэмжих зорилгоор боловсрол, эрүүл мэндийн салбарт бүсчилсэн хөгжил болон хувийн хэвшлийг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах хүрээнд эрчим хүч, суурь дэд бүтцийн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор онцгой байдлын салбарт, нийгмийн хэв журам аюулгүй байдлыг хангах үүднээс батлан хамгаалах, гадаад харилцаа, Хууль зүй, дотоод хэргийн салбарт шинэ хөрөнгө оруулалтыг түлхүү төлөвлөлөө.

Мөн олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд НҮБ-ын “COP-17” хурлыг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилт болон гадаад зээл, тусламжийн төслүүдийн Монголын талын хариуцах хөрөнгийг төсөвт тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 29.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2 их наяд төгрөгийн ашигтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь байж төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангахаар байна.

Иймд Монгол Улсын 2026 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

О.Номинчимэг: С.Бямбацогт сайдад баярлалаа.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч Монгол Улсын ерөнхий аудиторовн орлогч ирсэн байгаа. Тийм ээ. Болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Д.Рэгдэл гишүүнээр асуулт асуух гишүүдийн нэрсийг тасаллаа. 2 гишүүн нэрсээ өгсөн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүний микрофоныг өгье. Асуулт асууя.

Д.Рэгдэл: С.Бямбацогт сайдаас л асуух гэсэн юм даа. Тэгээд гараад явлаа даа.

Баярлалаа. Тэгээд манай 2026 оны төсвийн тухай хуулийн асуудал ерөнхийдөө жаахан хоцрогдолтой яваад байгаа. Тэгээд энэ бүхэн маань эмч, багш нарын цалинг нэмэхтэй холбоотой асуудлууд гээд тулгамдсан асуудлууд дээр нь нэмэгдээд байгаа юм.

Тэгэхээр Засгийн газрын зүгээс 2026 оны улсын нэгдсэн төсөв дээр нэлээн өөрчлөлт оруулж ирэх ийм нөхцөл үүсээд байна уу гэж харж байгаа. Тэгэхээр одоо хэвлэлээр ирж байгаа мэдээллээс харахад 830 орчим тэрбум төгрөгийн зардал шаардагдаад байна гэж яваад байгаа.

Тэгэхээр 830 гаруй тэрбум төгрөгийн зардлыг хөрөнгө оруулалтаасаа гаргах уу, эсвэл урсгал зардлаасаа гаргах уу гэдэг дээр Монгол Улсын Засгийн газар ер нь ямар байр суурьтай байгаа юм бол.

Ер нь саяын танилцуулгаас харахад шинээр эхлэх хөрөнгө оруулалт 1 их наяд гаруй төгрөг л байгаа юм байна. Өнгөрсөн жилийнхээсээ 2 дахин буугаад. Нөгөө урсгал зардлууд бүгд л хэмжээстэй л юмнууд байдаг. Засгийн газрын байр сууриудыг сонсьё гэж бодож байна аа? Баярлалаа.

О.Номинчимэг: Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Д.Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр бид Засгийн газар төсөв өргөн барихад төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, ялангуяа төсвийн урсгал зардлын хязгаар маань 24 хувь байна гээд Улсын Их Хурлаас батлаад өгсөн. Улсын Их Хурлын баталсан хуулийг зөрчиж энэ хязгаараас давсан зардлыг бид оруулж ирэх боломжгүй байсан.

Ийм учраас. Түрүүн Та хэллээ. Хөрөнгө оруулалтын зардлыг хоёр дахин бууруулсан. Мөн ахмадуудын тэтгэврийг 6 хувь нэмэхээр оруулж ирсэн. Багш, эмч нарын цалинг байгаа түвшинд байхаар төсвийн төслийг өргөн мэдүүлсэн.

Төсвийн төслийг 9 сарын 01-нээс эхлээд 45 хоногийн хугацаанд хэлэлцэж байгаа. Бид. Энэ хугацаанд эмч, багш нар шаардлага тавьсан. Ахмадууд санал хүсэлтээ гаргасан. Үүнтэй холбоотойгоор манай Засгийн газрын холбогдох сайд нар, тухайлах юм бол манай Т.Аубакир сайд, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр, мөн Тэргүүн Шадар сайд НУчрал зэрэг сайд нар маань ахмадуудын төлөөлөлтэй, багш нарын төлөөлөлтэй, мөн эмч нарын төлөөлөлтэй, түүнийг төлөөлж үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудтай уулзсан.

Энэ уулзалтуудад Их Хурлын гишүүдээ бас татаж оролцуулж салбар салбарын төлөөлөл болсон манай багш нарын төлөөллөөс Ж.Галбадрах багш, Ц.Мөнхтуяа багш, мөн Та. Дээрээс нь С.Эрдэнэбат гишүүн үйлдвэрчний эвлэлийнхэнтэй уулзах уулзалтуудад, эмч нарын төлөөллөөс бас манай холбогдох эмч нар, Т.Мөнхсайхан эмч гэх мэтийн Их Хурлын гишүүдтэй хамтарч оролцоод үндсэндээ Их Хурал, Засгийн газраас шаардлага тавьж байгаа багш нартай, эмч нартай, түүний үйлдвэрчний эвлэлүүдтэй ахмадуудтай, уулзалтууд хийгээд тодорхой зөвшилцөл, тодорхой ойлголцолд хүрч байгаа.

Энэ хүрээндээ үндсэндээ багш нарын цалин, эмч нарын цалинг нэмэгдүүлэх ахмадуудын тэтгэврийг нэмэгдүүлэх энэ асуудал дээр үндсэндээ ойлголцолд хүрч байна.

Үүнийг шийдэхдээ төсвийн 3 дугаар хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос төсвийн ажлын хэсэг гарч байгаа. Х.Ганхуяг Төсвийн байнгын хорооны даргаар ахлуулсан ажлын хэсгийн хүрээнд холбогдох хууль тогтоомжтой өөрчлөлт оруулаад. Өөрөөр хэлэх юм бол төсвийн урсгал зардлын хязгаар 24 хувиа өөрчлөөд үүнтэй холбоотойгоор тодорхой саяын яригдсан зардлуудыг шийдэх эх үүсвэрүүдийг суулгах боломж байгаа. Ингэхдээ мэдээж хөрөнгө оруулалтаас хасах уу, урсгал зардлаас хасах уу.

Ер нь сайд нарын багцад байгаа урсгал зардлаас хасах асуудал яригдаж байгаа юм билээ. Үүнээс боломжгүй зүйлүүдийг нь хөрөнгө оруулалтаас хасах. Мөн дахиад Засгийн газраас өргөн барьсан төсөв дээр Тавантолгойн бүлэг ордыг эдийн засгийн эргэлтэд оруулъя.

Энэ Бортээгийн орд гээд ашиглагдаагүй нэг орд байна. Энэ ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах юм бол үүнээс Монгол Улсын эдийн засагт, Монгол Улсын төсөвт орох орлого нэмэгдэх юм байна. Эндээс тодорхой эх үүсвэр гарах байх.

Мөн Рио Тинто компанитай Оюу Толгой төслийн талаар хэлэлцээр хийж байгаа. Энэ хэлэлцээрийг үр дүнтэй болгож, менежментийн зардлыг бууруулж

чадвал, хүүгийн зардлыг бууруулж чадах юм бол Оюу Толгой компаниас Монголын талын ногдох үр өгөөж нэмэгдэнэ.

Иймэрхүү боломжууд байгаа гэдэг дээр ажиллаж байгаа. Энэ дээр манай Их Хурал, ялангуяа Их Хурлын мэдэлд төсөв маань очсон байгаа учраас Улсын Их Хурал дахь Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүд маань энэ бодлогуудыг ойлгоод, дэмжээд ингээд холбогдох хууль тогтоомждоо өөрчлөлт оруулаад явах юм бол энэ о тулгамдаад байгаа багш, эмч нар, ахмадуудын асуудлыг шийдэх бүрэн боломж бүрдэнэ гэж бид ажиллаж байна.

О.Номинчимэг: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Төсөв дээр Д.Рэгдэл гишүүн асуусан. Одоо би яг тодорхой асууя. Одоо цаг тулсан учраас. С.Бямбацогт гишүүн ээ, Та байж байгаарай. Чухал асуудал учраас.

Яг одоо бид өмнө хоёр, гурван ч удаа уулзсан. Үйлдвэрчний эвлэлийнхнээрээ ч уулзсан. Яг энэ эмч, багш нарын цалин, энэ ахмадын юун дээр яг хэдэн төгрөг, хэдэн хувь гээд тавьчихаад байгаа юм бэ? Нэг талаасаа нөхдүүд 3 сая 500 гээд суугаад байгаа. Нөгөө талаасаа яг одоо байгаа төсөв дээр, бид нарын гар дээр байгаа төсөв дээр цалин хөлс нэмэх тал дээр мөнгө байхгүй шүү дээ. Тийм. Нэг.

Хоёрдугаарт, ер нь төсөв дээр ахмадууд гээд тавихад хуулиа барих юм бол 6 хувь гээд байгаад байгаа юм. Яг хуулиа барих юм бол Өргөдлийн байнгын хорооны бидний гаргасан дүгнэлтээр тэр чиглэлийн яам нь хамгийн доод тал нь инфляцуудаа дээшээ нэмнэ гэх юм бол 10.3 орчим хувиар нэмэх юу оруулаад ирсэн. Тэгэнгүүт манай төсөв зохиогч нар яаж байна вэ гэхээр үгүй ээ инфляц одоо ер нь буурах хандлагатай байгаа. Тийм учраас 6 хувь гэж тооцож байгаа. Бид тэгж муу ёрлож инфляц өснө гэж тооцохгүй гэдэг яг ийм аргаараа үүний өмнөх жил дээр мөнгөн дүн тавиад, үүний чинь хохирогч нь хэн болоод байна вэ гэхээр тэр хэмжээгээр тэр өөдрөг төсөөлөлтэй манай эдийн засагч нар, санхүүч нарын хохирогч нар нь бодит орлогоо инфляцад ахмадууд ажилд чинь халдаад байгаа байхгүй юу.

Цалин ч гэсэн түрүүн жил 6 хувь гэж байхад би шүүмжилж байсан. 6 хувийн цалин гэдэг бол бодитоор нэмэгдлийн асуудал биш ээ.

Тийм учраас манай төсөв зохиогч нар инфляцыг яг одоо хэд байна, яг оны төгсгөлд хэд гэж тооцоод байгаа юм гэдэг энэ зүйлийг асуумаар байна.

Дээрээс нь би дараагийн зарчмын саналууд оруулж ирэх гээд тавьсан. Одоо баахан хүний л, ялангуяа манай тойргийн гишүүдийн л уур уцаарыг хүргэж байх шиг байна. Уг нь би ямар зарчим тавьсан гэхээр зөвхөн урсгал зардлаас 10

хувийг татна гэх юм бол багш нар, эмч нар, ахмадуудын чинь тавьж байгаа шаардлагад хүрэхгүй ээ. Давхар хажуугаар нь тэр шаардлагагүй хойшлуулж болох хөрөнгө оруулалтуудаа оруулж ирээч ээ. 10 хувийг нь дахиад тавьчхаач. Тэгэх юм бол 700, 800 тэрбум төгрөг гарч ирэх гээд байна гэдэг саналыг хэлсэн. Тэгсэн дэгээрээ одоо юу гэж хэлж байна вэ гэхээр Та өөрөө түүчих. Өөрөөр хэлбэл аль хэний зардлаас яаж түүх гэдэг юм аа өөрөө түү гэхихээд энэ богино хугацаанд бид ямар санал оруулж ирж байна вэ гэхээр хойшлуулж болох, шинээр эхэлж байгаа ийм зүйлүүдийг нь би түүгээд оруулаад тавьсан юм. Уг нь үүнийг Засгийн газар өөрөө хийх ёстой байхгүй юу.

Тэгээд би ийм боломжийг гишүүдийг шахаанд оруулаад хооронд нь муудалцуулах төсвийн зарчим гэдэг. Би угаасаа буруу гэж бодоод байгаа юм. Үүнийг бол. Ний нуугүй хэлэхэд. Манай нөгөө гишүүд ч гэсэн бас уучлаарай. Би тэрийг үүнийг гэж буруу зөрүү санаж оруулж ирсэн зүйл байхгүй. Ерөнхий зарчим бол би ерөөсөө л маш ойлгомжтой тавьсан. 10-ыг нь тавиач ээ гэж.

24 хувь гээд сая С.Бямбацогт сайд яриад явлаа. Үүнийг Засгийн газар өөрөө л оруулж ирсэн шүү дээ. Өмнөх хамтарсан Засгийн газрын үедээ. Төсвөө барья, алдагдалгүй барья гээд. Нэмэлт 1 минутаа авъя. О.Номинчимэг дарга аа.

О.Номинчимэг: С.Эрдэнэбат гишүүнд нэмэлт тодруулгын 1 минут.

С.Эрдэнэбат: Тэгэхээр энэ тал дээр тэр 24 хувийн хязгаарыг Их Хурал баталсан учраас Их Хурлын үгэнд ороод бид ингээд цалин нэмэхийг оруулж ирэхгүй гэдэг нөгөө талаас нь яриад байх юм. Та хэд асуудал оруулж ирээд үүний өмнөх Засгийн газрын үед оруулж ирэнгүүтээ ер нь бол болно оо, бүтнэ ээ, бид одоо ингээд шийднэ ээ гэдэг байдлаар оруулж ирээд тэгээд Их Хурал олонх нь дэмжээд. Би бол тэрийг дэмжээгүй угаасаа анхнаасаа.

Тэгэхээр одоо Засгийн газар маань дагуулаад оруулаад ирэх боломж байгаа юм уу? Одоо хамаа алга. Ний нуугүй хэлэхэд одоо бид алдагдалтай. Энд тэндээс оруулсан хөрөнгө оруулалтаа хасаж байсны оронд магадгүй оны дундуур төсвөө хэмнэх боломжууд зөндөө гардаг. Түүнээсээ шилжүүлэх байдлаар энэ юмаа гацаанаасаа гарах юмыг Засгийн газар өөрсдөө тэр жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний л нэг заалт шүү дээ. Хууль биш энэ чинь. Тийм. Хуулиараа бол 30 гэж байгаа.

Тэгээд энд нь оруулж ирээд Засгийн газар өөрөө гацаанаас гарах юмаа оруулаад ирэх тийм санаа байна уу? Би хамгийн сүүлд Ерөнхий сайд эд нартай уулзаж байхад үүнийг хөндөхөөс өөр аргагүй байдал руу орох юм байна. Бид бас үүнийг судалж байна гэдгийг ярьж байсан. Тэгээд энэ тал дээр хариулт өгөөч.

О.Номинчимэг: П.Наранбаяр Боловсролын сайд оролцож байна. П.Наранбаяр сайдын микрофоныг өгье. Хариулт.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэр цалин нэмэгдүүлэхтэй холбоотой бид төсвийн нөлөөллийг судалж үзсэн.

Ингээд бас үйлдвэрчний эвлэлийн удирдлагууд, төлөөлөлтэй, багш нарынхаа төлөөлөлтэй уулзаж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд хамтран уулзалт хийсэн.

Энэ уулзалтуудын үр дүнд бид яг энэ боловсролын салбартаа 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлээд 509.9 тэрбум төгрөгийг нэмж тусгаснаар үндсэн цалингийн хэмжээг 20 хувь буюу суурь цалинг ярьж байгаа. Нэмэгдүүлэх боломжтой болно.

Үүнийгээ он гараад 2026 оны 7 дугаар сарын 01-нээс бас дахин 10 хувиар нэмэгдүүлэхэд нийтдээ 196 тэрбум төгрөг нэмж шаардагдана. Дахиж. Ингээд энэ салбарын, багш нарын үндсэн цалин 30 хувь нэмэгдэх боломжтой болох юм.

Ингэснээрээ үндсэн цалингийн суурь цалингийн хэмжээ 2 сая төгрөг рүү орох тооцоог хийсэн. Энэ дээр үйлдвэрчний эвлэлийн удирдлагуудтай ярилцаж хамтын хэлэлцээг эхлүүлэх саналаа тавиад нөгөө талаасаа хүмүүсийн нэрс ирэхийг хүлээгээд байж байгаа юм. Ийм нөхцөл байдалтай байна.

О.Номинчимэг: Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамныхан орж ирсэн юм уу? Уг нь Эдийн засаг, хөгжлийн яам хариуцах ёстой шүү дээ. Эдийн засаг, хөгжлийн яамнаас хэн байна? Инфляцтай холбоотой асуудлыг хэн хариулах вэ? Та хариулах юм уу? Статистик байна уу? Статистик ч байхгүй. Тийм ээ. Т.Аубакир сайд Засгийн газрыг төлөөлөөд хариулъя.

Т.Аубакир: Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Манай Улсын Их Хурлын гишүүд, түүн дотроос манай С.Эрдэнэбат гишүүн, Ц.Мөнхтуяа гишүүн нар бас багш нарын төлөөлөл болж орж ирсэн. Мэдээжийн хэрэг боловсролынхоо салбарт аливаа улс илүүтэй хөрөнгө оруулалт тавьж багш нарын нийгмийн баталгааг маш сайн өндөр түвшинд хангаж явах ёстой гэдэгтэй санал нэг байгаа.

Цалин, тэтгэвэр нэмэхтэй холбоотой багш, эмч нарын, ахмадуудын тэтгэврээ нэмэхтэй холбоотой Засгийн газар удаа дараа арга хэмжээнүүдийг аваад төсвөө шахаад янз бүрийн байдлаар үзээд явж байгаа. Гэхдээ зарим тохиолдолд бид эргэж сайн харахгүй бол эргээд багш, эмч нарын буюу зарим төрийн албан хаагч нарын цалинг нэмснээрээ бид нөгөө 60 гаруй мянган эдийн

засгийг авч явж байгаа хувийн хэвшлүүдээ бас араасаа чирэх ийм эрсдэлтэй байгаа. Эднийгээ бид бас тооцож үзэх хэрэгтэй. Эргээд өргөн хэрэглээний барааны өртөг нэмэгдээд эхэлнэ. Ингээд бид эдийн засгаа, инфляцаа ямар байдалд хүргэх вэ гэдэг дээр маш болгоомжтой хандаж байгаа.

О.Номинчимэг: 1 минут нэмэлтээр Т.Аубакир сайд.

Т.Аубакир: 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээр 9.5 гэсэн хувь явж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр. Одоо яг гүйцэтгэл нь 8 хувьтай байгаа учраас тэтгэврийг 8 хувьтай нийцүүлж нэмэх хуультай.

Тийм учраас энэ хуулийн хүрээнд өргөн барьсан төсөв дээрээ бид 6 гэж оруулж ирсэн. Одоо 8 гэдэг тоо явж байгаа.

Тийм учраас ахмадын тэтгэврийг нь бид инфляцтайгаа уялдуулж 8 хувь нэмэх нь зүйтэй гэсэн. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр 9.5 гэсэн тоо явж байгаа.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Гишүүддээ хэлэхэд одоо үг хэлэх гишүүдийг авсны дараа бид 53 зарчмын зөрүүтэй саналын томьёолол байгаа. Маш анхааралтай бүгдээрээ саналын томьёолол дээрээ анхаараад, бас саналуудаа хэлээд санал хураах байгаа шүү гэдгийг хэлье.

Үүнээс өмнө төсвийн төсөлтэй холбоотойгоор үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. С.Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүнд микрофон өгье.

С.Эрдэнэбат: Тэгээд юманд нөгөө бас тодорхой хариулах бол дараа дараагийн шийдвэрт их хэрэгтэй байгаа юм. Яах вэ, инфляц бол одоо 8 хувь л байна гэж байна. Яг бодит байдал дээр бол улсын дундаж тийм байгаа байх. Цаашаа оны төгсгөл рүү өсөөд яах хандлага би байна гэж бол хараад байгаа юм.

24 хувь дээр бол тахиа анхдагч уу, өндөг анхдагч уу гэдэг л юм яриад байна л даа. Засгийн газар 24 хувьд барья гээд оруулж ирсэн. Тэрийг нь Их Хурал дэмжсэн. Засгийн газар үнэхээр багш, эмч, ахмадынхаа асуудлыг гайгүйхэн төсөв гаргаад шийдье гэж бодож байгаа бол алдагдалтай төсөв баталъя. 24-ийнхөө хязгаарыг өөрчлөх хэрэгтэй байна гэдэг саналаа өөрсдөө оруулаад ирэх эрх нь Та нарт байгаа шүү дээ. Хууль санаачлах эрх нь Засгийн газарт өөрт нь байгаа.

Төсөвтэй холбоотой дагасан хуулиуд дээр Засгийн газар л өөрөө асуудал оруулж ирэх ийм хуультай байгаа. Их Хурлын гишүүдэд хязгаарлагдмал байгаа.

Тийм учраас 24 хувийнхаа энэ боломж гэдэг юмыг Засгийн газар өөрөө ашиглавал яасан юм бэ. 24 хувийн тоог хаанаас олж ирээд тавьсан юм гэхээр хэлэх хүн олдохгүй юм байна лээ. Тэгээд бодож байгаад тэгээд одоо ерөнхийдөө 24 хавьцаа байхаар нь эндээ барья гээд барьсан юм гээд. Яг бодит байдал дээр чинь өнөөдөр П.Наранбаяр сайд шахаанд ороод сууж байгаа, Т.Аубакир сайд өөрөө шахаанд ороод сууж байгаа, Сангийн сайд шахаан д ороод сууж байгаа.

Үндсэн цалингуудаа багш, ажилчдынхаа цалин хөлс орлогыг ядаж 3 сая 500-д болгоё. Ахмадууд тэтгэврээ 6 хувь гээд сууж байна. Ядаж 200, 300 мянган төгрөгөөр нэмье ээ л гэдэг нэг ийм бодит шаардлага шахалтад орж ирээд сууж байгаа учраас Засгийн газрын л ажил шүү дээ.

Тэгээд Их Хурал бол дэмжье гэж байгаа. Одоо манай Их Хурлын 50-иад гишүүд төсвийн гаргалгаагаа аваад ирэх юм бол боловсролынх нь эх үүсвэр дээр нь дэмжээд өгье.

Тэгэхээр энэ боломжоо ашиглаач ээ гэдгээ хэлэхгүй байна. Тэгэхгүй бол одоо ингэж явсаар байгаад гаднаа жагсаал цуглаан тэмцэлтэй, дотроо хэрүүл маргаантай, тэгээд өвөл ирэх жил чинь ер нь бараг хүндхэн л өнгөрөх ийм дүр зураг харагдах гээд байна шүү дээ.

Тийм учраас Засгийн газар, Их Хурал хоёр талцаж чи би гэхийнхээ оронд асуудлынхаа дунд уулзмаар байна. Төсөв ч гэсэн одоо яг ний нуугүй хэлэхэд Их Хурлын гишүүд дотор жагсаасан баахан тоо байдаг. Ямар учраас яагаад яаж эрэмбэлсэн юм гэдэг хариултад хэн ч өгөхгүй байгаа.

Тийм учраас одоо энэ төсөв дээр зарчмын санал дээр манай бүх яамдаас ирсэн байна лээ. Тийм учиртай юм гэж. Уг нь төсвийн нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг дээр энэ асуудал дээрээ тайлбараа өгөөд, мэдээллээ өгөөд, гишүүддээ тайлбараа өгөөд явсан бол энэ ойлголтыг авахаар байлаа. Тэгээд ийм зүйлийг хэлмээр байна.

Тэгээд өчигдөр би 30 хувь гээд Засгийн газар яг багш нар дээр бол 30 орчим хувь гээд тоо яриад байна. Үүнийгээ яг албан ёсоор шийдсэн тушаал, шийдвэр байна уу. Хэлэлцээрээрээ албажуулаарай. Тэгээд нэг тоон дээр уулзах хэрэгтэй болно шүү дээ. Нэг нь 3 сая 500 гэсэн. Нэг нь 0-ээс эхэлж байгаа.

Тэгэхээр ийм зүйл дээр хэлэлцээр хийж баталгаажуулж авахгүй бол, төсвөөс өмнө үүнийгээ шийдэхгүй бол төсвийн дараа бол наадах чинь их тун хэцүү байдал руу орно. Тийм санал хэлсэн чинь одоо ингээд 30 хувь л болоод

дуусах юм байна. Их Хурал ч гэсэн ийм байр суурьтай байгаа юм байна гэдэг байдлаар.

Үүнийг одоо орон даяараа үзэж байгаа байх. Их Хурлын гишүүд аль болохоор тэр багш, эмч, ахмадуудын тавьж байгаа санал шаардлагад нь хүрээч ээ гэдэг л ийм байр суурьтай байгаа. Дийлэнх нь.

Яах вэ, тэгээд тэр тойрог мойргийн зарим гишүүд нь миний тойрог дээр байгаа замыг хаслаа, миний тойрог дээр байшин хаслаа гээд жоохон ууртай байх шиг байна лээ.

Тэгэхдээ яг өнөөдөр тэр тойргийн гишүүд чинь тэнд ажиллаж амьдарч байгаа багш нар, тэнд ажиллаж амьдарч амьдарч байгаа эмч нар, тэнд ажиллаж амьдарч байгаа ахмадуудын цалин, тэтгэврийг нэмье. Эргээд өрхийн орлогыг нэмье, иргэдийнхээ орлогыг нэмье гэдэг дээр нь эрэмбийн хувьд нэг номерт юм байна гэдэг байдлаас нь л энэ асуудалд хандаж байгаа шүү гэдгийг би санал хураалгахаас өмнө зориуд цохон тэмдэглэж хэлье.

Тэгээд зарчмын саналууд гарч байгаа дээр манай холбогдох яам, Тамгын газрынхан бас яах вэ нэмэлт тодруулга бас өгөөрэй. Би бол тэрийг сонсож байж бас энэ саналынхаа асуудал дээр хандъя гэж бодож байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлж дууслаа. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны гишүүдээс ажлын хоёр өдрийн өмнө урьдчилж ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор одоо санал хураалт явуулж эхэлнэ.

Байнгын хорооны гишүүдэд тараасан байгаа. Нийт санал хураалгах 52 зарчмын зөрүүтэй. 53 уу? Нийт санал хураалгах 53 зарчмын зөрүүтэй саналын томьёолол байгаа.

Улсын Их Хурлын 3 гишүүдээс зарчмын зөрүүтэй саналын томьёолол ирсэн байгаа.

Улсын Их Хурлын гишүүдээс буюу Сүхбаатарын Эрдэнэбат, Даваасамбуугийн Ганмаа, Ганзоригийн Лувсанжамц гишүүн болон олон гишүүдийн саналыг гаргасан. Ажлын хэсэг ч биш байх. Олон гишүүдийн санал байх. Тийм ээ. Ийм саналуудыг гаргасан байгаа.

Тэгэхээр уг саналыг уншсаны дараа энэ саналтайгаа холбогдуулан гишүүд саналаа тайлбарлаж болно. Тэгээд үүнтэй холбоотой Засгийн газар,

төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрсдийн байр суурийг илэрхийлэх боломжтой байгаа шүү гэдгийг хэлье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.3-д зааснаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал гаргасан гишүүн саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно.

Ингээд Байнгын хороонд ирсэн эхний нэгдүгээр саналын томьёоллыг уншъя.

Нэлээн урт саналын томьёолол байгаа. Ажлын хэсгийнхэн бас өөрсдөө анхаарна биз. Өөрсдөө оролцож ирээгүй хүмүүс байвал одоо тэгээд яах вэ дээ. Тийм ээ. Байнгын хороонд оролцохгүй байгаа юм чинь.

Саналын томьёоллыг уншъя.

1.Боловсролын салбарын урсгал зардлыг **350.0 тэрбум** төгрөг, Эрүүл мэндийн салбарын урсгал зардлыг **114.4 тэрбум** төгрөг, Ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэлдүүлэхэд **100.0 тэрбум** төгрөг, нийт **564.4 тэрбум** төгрөгийг дараах төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг бууруулж болон төслөөс хасаж шийдвэрлэх. Үүнд:

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600080 төслийн кодтой “Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **32,544.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **16,272.2 сая** төгрөгөөр тус тус бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200838 төслийн кодтой “Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,356.4 сая** төгрөг, санхүүжих дүн **1,064.5 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **1,064.5 сая** төгрөгөөр бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200599 төслийн кодтой “Нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд оролцох цагдаагийн багийн тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 10,080.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **5,040.0 сая** төгрөгөөр бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200991 төслийн кодтой “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг

6,467.8 сая төгрөг, санхүүжих дүн 1,940.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг **1,940.0 сая** төгрөгөөр бууруулах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200382 төслийн кодтой “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,968.3 сая** төгрөг, санхүүжих дүн **1,785.7 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг **1,785.7 сая** төгрөгөөр бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200517 төслийн кодтой “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга /Өвөрхангай, Хархорин сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **14,609.5 сая** төгрөг, санхүүжих дүн **3,652.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг **3,652.4 сая** төгрөгөөр бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400285 төслийн кодтой “Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Баруун бүс/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **19,657.7 сая** төгрөг, санхүүжих дүн **7,942.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг **3,971.2 сая** төгрөгөөр бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400293 төслийн кодтой “Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **26,586.5 сая** төгрөг, санхүүжих дүн **7,976.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг **3,988.0 сая** төгрөгөөр бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400232 төслийн кодтой “Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **20,132.1 сая** төгрөг, санхүүжих дүн **9,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг **4,500.0 сая** төгрөгөөр бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601300905 төслийн кодтой “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **150,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **75,000.0 сая** төгрөгөөр тус тус бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601300966 төслийн кодтой “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал

зохион байгуулахтай холбоотой тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **67,119.0 сая төгрөг**” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **33,559.9 сая төгрөгөөр** тус тус бууруулах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601300863 төслийн кодтой “Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх Доплерын Радарын станц /Өвөрхангай, Хархорин сум, Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **19,800.0 сая төгрөг**” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **9,900.0 сая төгрөгөөр** бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808085 төслийн кодтой “Аргалант-Баянцогт сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 26.7 км, төмөрбетон гүүр, 36 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг **44,729.5 сая төгрөг**, санхүүжих дүн **15,166.3 сая төгрөг**” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808211 төслийн кодтой “Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг **39,472.1 сая төгрөг**, санхүүжих дүн **15,000.0 сая төгрөг**” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808162 төслийн кодтой “Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг **150,926.6 сая төгрөг**, санхүүжих дүн **23,000.0 сая төгрөг**” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804339 төслийн кодтой “Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км /Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг **66,368.6 сая төгрөг**, санхүүжих дүн **42,904.6 сая төгрөг**” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804371 төслийн кодтой “Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг **44,988.8 сая төгрөг**, санхүүжих дүн **30,499.8 сая төгрөг**” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804360 төслийн кодтой “Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт сум хүртэлх

хатуу хучилттай авто зам, 43.3 км /Өвөрхангай, Хужирт сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг **69,037.3 сая** төгрөг, санхүүжих дүн **38,576.2 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804406 төслийн кодтой “Ховд-Дөргөн сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 40.7 км /Ховд, Дөргөн сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг **49,854.2 сая** төгрөг, санхүүжих дүн **25,159.7 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804412 төслийн кодтой “Хэрлэн голын төмөрбетон гүүр, 265 у/м, хатуу хучилттай авто зам, 14.2 км /Хэнтий, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг **49,920.1 сая** төгрөг, санхүүжих дүн **21,065.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102800632 төслийн кодтой “Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122.4 км /Төв, Угтаалцайдам, Цээл, Заамар сум/, хэрэгжих хугацаа 2022-2026 он, төсөвт өртөг **182,566.3 сая** төгрөг, санхүүжих дүн **80,101.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800805 төслийн кодтой “Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **106,868.4 сая** төгрөг, санхүүжих дүн **20,036.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800888 төслийн кодтой “Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **60,156.2 сая** төгрөг, санхүүжих дүн **18,046.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **170,899.7 сая** төгрөг, санхүүжих дүн **25,635.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800907 төслийн кодтой “Хэрлэн голын төмөрбетон гүүр, 217.6 у/м /Дорнод, Хэрлэн сум/ хэрэгжих

хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **22,845.1 сая** төгрөг, санхүүжих дүн **6,053.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/ хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **8,396.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,778.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2403100364 төслийн кодтой “Өвлийн спортын ордны барилга /Дархан-Уул, Дархан сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **22,438.0 сая** төгрөг, санхүүжих дүн **6,423.7 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900758 төслийн кодтой “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг **23,484.9 сая** төгрөг, санхүүжих дүн **6,130.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900178 төслийн кодтой “Үр тариа хадгалах агуулах /Увс/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **9,000.0 сая** төгрөг, санхүүжих **4,050.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602001067 төслийн кодтой “Хавдар судлалын Үндэсний төв-II” цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **234,232.9 сая** төгрөг, санхүүжих **40,523.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **20,261.0 сая** төгрөгөөр бууруулах;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602001014 төслийн кодтой “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой Улсын хоёрдугаар төв эмнэлэгийн Үндэсний оношилгоо, эмчилгээний төв барилгын их засвар /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **4,383.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **2,191.5 сая** төгрөгөөр тус тус бууруулах;

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат гэжээ. Энэ бараг манай төсөв дээр уншигдсан хамгийн урт зарчмын зөрүүтэй санал байх шиг байна. Ер нь л их хэцүү санал байна даа. С.Эрдэнэбат гишүүн ээ.

С.Эрдэнэбат гишүүн горимын санал гаргах юм уу? Тайлбар хийх юм уу?
С.Эрдэнэбат гишүүн тайлбар хийе.

С.Эрдэнэбат: Яах вэ, хэцүү санал нь бол хэцүү санал. Гэхдээ Засгийн газарт цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг нэмүүлэхэд эх үүсвэр гаргана гэж Засгийн газар өөрөө хэлсэн. Урсгал зардал болон хөрөнгө оруулалтаас би адилхан 10, 10 хувь танаач ээ гэдэг саналыг хүргүүлсэн.

Тийм учраас өөрөө хаанаас танах гэдэг зарчмыг нь ширхэгчлэн оруулж ир гэдэг учраас ингэж орж ирж байгаа. Санал хураах дээр би нэг нэгээр нь хураая. Эндээс би татах санал ч байна. Ялангуяа цэрэг армитай холбоотой, ил далд ярьж болдоггүй асуудлууд байна. Ззаримыг нь би яг нэг нэгээр нь хураагаад дээд байгаа нэмэлт нийт дүнгээс нь хасагдсан саналуудыг нь хасаад үлдсэн дээр нь 60, 20, 20 гэсэн харьцаатайгаар боловсрол дээр 60, эрүүл мэнд дээр 20, ахмад дээр 20 гэсэн саналаар үлдсэн төсвийг нь ахмадын тэтгэвэр, боловсролын цалин, эрүүл мэндийн эмч цалин гэдэг байдлаар хуваарилъя гэдэг горимоор хурааж өгөөч ээ гэдэг саналыг хэлмээр байна

Хоёрдугаарт, манай Байнгын хороонд байдаг ч гишүүд ч гэсэн, сайд нар ч гэсэн бүгдээрээ л үүнийг хасахгүй, тэрийг хасахгүй л гэж байх шиг байна.

Хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг дээр хэрвээ үнэхээр яриад цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг боломжийн эх үүсвэр дээр нь оруулж ирээд Засгийн газар өөрөө оруулж ирээд яриад шийдэх юм бол би үүнийг заавал нэгдсэн чуулган руу оруулаад бүгдийг нь хураалгаад байх шаардлагагүйгээр явцын дунд би татаж болно.

Гэхдээ ний нуугүй хэлэхэд өнөөдөр бүгдийг нь татахад төсвийн урсгал яг энэ байдлаараа, ийм зарчмаараа яваад, нөгөө тойрог, тойрог, сайд, сайд нь багцынхаа юмыг хамгаалаад, нөгөө цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, ахмадынхаа тэтгэврийн, багш, эмч нарынхаа цалин хөлсийг нэмэх гэдэг энэ зарчмаасаа ухраад явах юм бол үүнийг нэгдсэн чуулгандаа цаашаа явахаас өөр арга байхгүй.

Тэгэхээр миний гол санал хураалгаж байгаа зорилго бол хэн нэгний тавиулсан тэр төсөв, санхүүг хасна гэхээсээ илүүтэйгээр нөгөө эх үүсвэр зарчмыг л оруулж ирье гэдэг ийм зарчим барьсан шүү гэдгийг би онцгойлж хэлмээр байна.

Тийм учраас энэ саналуудыг бүгдийг нь хураана гэдэг бол угаасаа байж болохгүй. Би тодорхой хэлсэн. Гурван эх үүсвэрт 60, 20, 20 гэдэг хувилбараар хуваагаад тавина. Эндээс хэмнэгдсэн зардлуудыг.

Үүн дотроо яах вэ, сая зарим Засгийн газрын шийдвэр нь гарсан, ажлууд нь хийгдээд сүүлийнхээ шатад тэр байж байгаа ганц нэгэн бага өртөгтэй зардлууд байна. Тэр СОР-той холбоотой олон улсын байгууллагын өмнө хүлээсэн янз янзын юмнууд байгаа. Гэхдээ үүнийг би бүгдийг нь төр хийгээд, бүгдийг нь төр өөрөө байшин сав бариад гэхээсээ өөрөө төр, хувийн хэвшил, бусад байгууллагуудын оролцоо дэмжлэгээр буцаад тэр барьсан байшингаа зарах, борлуулах, эсвэл хөрөнгө оруулалтаас нь тэндээс нь татах гэдэг юм уу ийм чиглэлээр хийж болохгүй юу гэдэг үүднээс л үүнийг оруулсан юм.

Тэгээд ийм ийм байдлаар асуудлууд байна. Зарим нь яг ний нуугүй хэлэхэд би Их Хурлын гишүүддээ бүгдэд нь хэлмээр байна. Нэг жилдээ зам барих гэдэг юм уу, байшин барих гэдэг юмаа жоохон хойшлуулж болохгүй юу? Та хэд тэр тойрог тойргийнхоо гишүүдээс очоод асуу л даа. Энэ ахмад, боловсрол, эрүүл мэндийнхээ салбарт ахмадынхаа тэтгэврийг нэмэх, боловсрол, эрүүл мэндийнхээ ажилчдын цалинг нэмэх нь чухал уу, зам барих нь чухал байна уу гэдэг дээр санал асуулга аваад үз.

Тийм учраас би ийм л зарчмын санал хэлж байгаа. Түүнээс биш над руу янз янзын мессеж бичээд, янз янзын байдлаар хандаад байх шаардлага байхгүй. Монгол Улсын төсөв нэгдсэн нэг зарчимтай байх ёстой.

Би тэгэхээр хөрөнгө оруулалтаас Засгийн газар өөрөө мэдээд 10 хувийг танаад 800 тэрбум оруулж ирээд, урсгалаас 800 орж ирэх юм байна. Тэгээд 1.6 орчим их наяд төгрөгөөр цалин тэтгэврээ нэмье л гэдэг итгэл үнэмшил байгаа.

Тэгэхээр энэ зүйл дээр л Та бүгд маань зөвөөр ойлгоорой. Тэгээд зарчмын хувьд салгаад хураалгаач. Би заримыг нь татъя. Заримыг нь үүгээрээ яваад тэгээд төсвийн явцад ойлголцож болох болов уу гэж бодож байна.

О.Номинчимэг: Ийм байна С.Эрдэнэбат гишүүн ээ.

Таны Байнгын хороонд гаргасан саналын хуудас энэ байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.8-д нам, эвслийн бүлэг, гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага тодорхой төсөл, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах, түүнчлэн татвар бууруулах санал гаргасан бол мөн хэмжээгээр, зардал бууруулах саналыг хамтад нь гаргана.

Нэг санал болгон санал хураалт явуулах бөгөөд саналуудыг багцлан хурааж болно гэсэн ийм дэгийн хуулийн заалттай юм байна.

Тэгээд таны ирүүлсэн санал ерөнхийдөө сая уншсаны дагуу

- боловсролын салбарт нийтдээ **350.0 тэрбум төгрөг** гаргая,
- эрүүл мэндийн салбарт **114.4 тэрбум төгрөг** гаргая,
- ахмад настнуудын тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэл **100 тэрбум төгрөг** гаргая.

Үүнийгээ түрүүн маш олон хуудас, хэдэн минут ч уншив. Энэ бүх арга хэмжээнүүдээс ингэж ингэж хасъя гэдэг ийм санал байгаа байхгүй юу.

Тэгээд хэрвээ таны хэлж байгаагаар уг нь энэ чинь хоёр өдрийн өмнө гаргасан санал. Түрүүн Байнгын хороо эхлэх гэж 2 цаг 30 минут боллоо. Саналын томьёолол хийгдээд бүгдээрэнд нь тараагдсан. Та бол ирцдээ цагтаа орсон гишүүн. Энэ саналын томьёоллоо хараад энэ чинь болохгүй байна гэсэн бол өнөөдөр гэхээсээ илүү өмнө нь л Байнгын хорооны ажлын алба. Тийм ээ. Төсвийн зөвлөхүүдтэйгээ ажиллах л ёстой байсан байна гэж харж байна.

Тэгэхгүй бол одоо таны хүслээр, таны саналаар нэг нэгээр нь нь хураалгана гэх юм бол нэг бүрчлэн саяын хэлсэн төслүүдийг хасаад боловсролын салбарынх нь алинд оруулах юм, эрүүл мэндийн салбарын алинд оруулах юм гэдэг бүгдийг нь задлах хэрэгтэй болох гээд байна.

Тэгээд Та бол өөрөө тэгж саналаа гаргаагүй юм байна шүү дээ. Бүхэлд нь тавьсан байгаа байхгүй юу. Бүхэлд нь тавьсан байгаа саналыг сая төсвийн зөвлөх дэг сахиулж байгаа Байнгын хорооны ажлын албанаас ингээд бүхэлд нь авсан болохоор бид хуваах боломжгүй. Үүгээр нь санал яасан.

Одоо тодруулаад байхаар нааш цааш яваад байх байх.

Тэгэхээр чинь нэг л ийм санал болоод байгаа байхгүй юу.

Одоо ингээд задалж хураана гэх юм бол Та бүхэн яг дэгийн хуулийнхаа дагуу болж байна уу, үгүй юу гэдгийг хэлэх ёстой. Тамгын газрынхан, ажлын албаны ахлах зөвлөх бол яг энэ хуралдааны дэг сахиулах дэгийн зөвлөх нь байдаг.

Улсын Их Хурлын чуулганыг хуралдаж байгаа хуралдаан даргалагчийн хувьд ч гэсэн Ерөнхий нарийн бичгийн дарга дэгийн зөвлөх байдаг. Тэгээд энэ дэгээ зөв, буруу тайлбарласнаас болоод өчигдөр юу болж байгааг Та бүхэн харж байгаа.

Тэгэхээр Тамгын газрын мэргэшсэн хүмүүс дэгээ өөрсдөө аягүй сайн тайлбараа протоколд үлдээхээр тэгвэл үүнийгээ тайлбарлаадах. Тийм ээ. Болох юм уу, үгүй юм уу? Болохоор яаж хурааж болох юм гэдгийг.

Саналтай холбогдуулан юутай ч бас нөгөө төсвийн ерөнхийлөн захирагч нар тайлбар хийх эрхтэй. Түрүүн хамгийн эхэнд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд Б.Батбаатар тайлбар хийе ээ гэсэн хүсэлтийг гаргасан.

Гэхдээ юу яая тэгэх үү. Энэ чинь дэгээрээ нөгөө тайлбар хийх юугаа бид чинь нэрсээ авах ёстой. Байж байгаарай. Энэ дээр эхний гаргасан Сүхбаатарын Эрдэнэбат гишүүний саналтай холбогдуулан Засгийн газраас тайлбар өгөх гишүүд нэрсээ өг. Дарчих. Та дарга. Тийм. Б.Батбаатар сайд, Ч.Ундрам сайд тайлбар өгөхөөр нэр өглөө.

Батын Батбаатар сайд.

Б.Батбаатар: Нэгдүгээрт нь, бид төсөв хэлэлцэж байгаа энэ цаг үед “COP-17” гэж юу юм бэ гэдгээ ойлгох хэрэгтэй.

1961 онд Монгол Улс НҮБ-ын гишүүн улс болсноор тусгаар улс боллоо гэдгээ улс даяараа баярлаж хүлээж авсан. Одоо хүртэл тэрийгээ дурдаж байдаг. НҮБ-ын 197 улсын нэгдсэн цөлжилтийн эсрэг конвенцын талуудын бага хурал 297 хоногийн дараа Улаанбаатарт эхэлнэ. 297 хоног. Хэд хоног нь хүйтэн цаг ууртай байгаа билээ.

Тэгэхээр энэ төсвийг хэмнэх боломж урьд нь байсан уу гэвэл байсан. Одоо бол 297 хоног дотор бид ямар ч боломжгүй.

Ер нь өмнөх COP-уудыг аваад үзэхэд гаргасан зардлаа хамгийн багадаа 20 дахин нэмэгдүүлсэн хөрөнгө оруулалт босгож байдаг. Хамгийн сүүлд “COP-16” гэхэд 500 сая долларын зардал гаргаж хурлаа хийгээд 12 тэрбум 150 сая долларын хөрөнгө оруулалт татсан. Тэрний өмнөх COP нь 2.5 тэрбум долларын хөрөнгө оруулалт татсан.

Тэгэхээр би Их Хурлын эрхэм гишүүдийг энэ тусгаар улсынхаа хувьд НҮБ-ын 197 улс нэгдсэн энэ COP-17-г зохион байгуулах зүйл дээр Монгол Улсын газар нутгийн 77 хувь нь цөлжилтөд өртсөн ийм нөхцөл байдал дээр үүн дээр анхааралтай хандаач ээ гэж хүсэж байгаа.

Одоо бид үүнээс ухрах юм уу, өөрчлөх боломжгүй болсон. Конвенцын талуудын нарийн бичгийн даргын газартай хэлэлцээрээ хийсэн. Хүлээн авагч улс орны хувьд гарын үсгээ зурсан. Энэ ажил тодорхой хэмжээнд тийм үр дүнтэй сайн ажил болж чадаагүй явсан. Үүнийг сүүлийн 100 гаруй хоног дотор ажлыг нь нэлээн эрчимжүүлж байгаа.

Хамгийн багадаа хурал зохион байгуулахад гадаад, дотоодын донор улс орнууд, олон улсын байгууллагуудаас тодорхой хэмжээний хурлын зардлын мөнгө босож ирэх байх. Тэр хандивын мөнгө ороод ирвэл энэ төсөвт тавигдсан

мөнгө эргээд хэмнэгдээд бусад улс оронд хэрэгтэй олон зардлуудыг санхүүжүүлэхэд хэрэг болно.

Тэгэхдээ бид хандив олж ирнэ гэж бодоод ингэж ажиллаж бас болохгүй.

Тийм болохоор С.Эрдэнэбат гишүүн болон СОР-ын зардлаас хасаж байгаа 3 зардал байж байна. 75 тэрбум, 33 тэрбум, 5 тэрбум гээд энэ саналаа татаад авчаач ээ гэдэг хүсэлтийг өгч байгаа юм.

О.Номинчимэг: Чинбатын Ундрэм сайдын микрофон өгье.

Ч.Ундрэм: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хувьд 2026 оны төсөвт бид маш тийм даруухан, аль болохоор шинэ бүтээн байгуулалт гэхээсээ илүүтэй хуучин эхэлсэн байгаа бүтээн байгуулалтуудаа дуусгах хэмжээний бид төсвийн төслийг өргөн барьсан байгаа.

Тэгээд энэ дээр нийт ерөөсөө өмнөх жилүүдтэй харьцуулах юм бол маш бага хөрөнгө оруулалт байгаа. Нийт 62 хөрөнгө оруулалтын ерөөсөө 4-хөн нь шинэ хөрөнгө оруулалт. Бусад нь дандаа хуучин юмнуудаа дуусгах. Энэ 4 хөрөнгө оруулалтын 3 нь спорттой холбоотой барилга, байшингийн хөрөнгө оруулалт. Нэг нь аялал жуулчлалын.

Тэгээд энэ сумдад байгаа бидний хойч үе, үр хүүхдүүд, тэд нар маань дэлгэцийн хамааралтай, дээрээс нь бие бялдрын хөгжлийн хувьд ч гэсэн жилээс жилд муудаж байна.

Тийм учраас бид сумдад энэ спортын барилга, байгууламжуудыг барьж энэ хүүхдүүдийг дэлгэцээс илүүтэй спортод, биеийн тамирт дуртай болгох ийм бодлого бариад ажиллаж байгаа юм.

Тийм учраас 4-хөн хөрөнгө оруулалтаас маань энэ таны санал дээр 2-ыг нь хасъя гээд оруулаад ирсэн байна. Гэтэл одоо жишээлбэл нэг нь энэ Баян-Өлгий аймгийн Өлгий сум гээд аймгийн төв л дөө. Энэ аймаг 118 мянга гаруй хүн амтай. Тэгээд ихэнх нь аймгийн төвдөө амьдардаг. Нийт хүн амынх нь 40 хувь нь өсвөр насны хүүхэд, залуучууд байж байдаг. Тэд нар маань орж хичээллэх спорт заал ерөөсөө байхгүй. Сэлэнгэ аймгийн Сайхан сум гээд 10 гаруй мянган хүн ам амьдарч байна. Бас спорт заал ерөөсөө байхгүй. Тэнд байгаа хүмүүсээс асуугаад хамгийн хэрэгтэй хөрөнгө оруулалт юу байна гээд асуухаар спорт заал гээд нэг номерт гарч ирдэг байхгүй юу.

Тэгэхээр ийм зардлуудыг маань хасахаа болиоч ээ. Жишээлэх юм бол төвийн бүсийн тойргоос хоёр удаа сонгогдсон. Тэнд байгаа хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг маш сайн мэдэж байгаа. Одоо энэ Цээл, Угтаалын замыг бас хасна гээд санал ороод ирсэн байна.

Гэтэл энэ чинь манай тариаланчдын гол зам болох гээд байгаа байхгүй юу. Газар тариалангийн тойрог зам гэж Төв аймаг, Сэлэнгэ, Эрдэнэтийг холбосон тойрог зам болох гэж байгаа юм. Тэгээд үүгээр манай тариаланчид тариа будаагаа зөөх, төмс, хүнсний ногоогоо зөөхөд маш чухал эдийн засгийн ач холбогдолтой зам байхгүй юу. Зүгээр л нэг зам барих гээд байгаа асуудал биш. Тухайн орон нутагт амьдарч байгаа хүмүүсийн нэг номерын асуудал бол энэ замын асуудал байдаг.

Тариа будаагаа замгүй, шороон замаар зөөхөөр хоргодол нь маш өндөр гараад байна. Төмс, хүнсний ногоогоо шороон замаар зөөхөөр хоргодол нь маш өндөр гараад байна гээд. Гэх мэтчилэн энэ чинь дандаа тухайн орон нутагт амьдарч байгаа хүмүүсийн эрх ашиг хөндөгдөж байгаа байхгүй юу. Энэ чинь зөвхөн гишүүдийн эрх ашиг биш. Тэнд амьдарч байгаа ард түмний эрх ашгийн төлөө энэ төсвүүдийг чинь бид өчнөөн жил хөөцөлдөөд, энэ замыг ач холбогдлыг нь хэлж ойлгуулаад, зураг төсвийг нь хийгээд барилга, байгууламжийн ажил нь хийгдээд явж байгаа. Гэрээ байгуулагдсан. Тэнд чинь бас том аж ахуйн нэгж орсон. Бүтээн байгуулалт хийгээд явж байгаа. Ирэх жилийнхээ төлөвлөгөөг гаргасан явж байгаа.

Энд чинь зүгээр л бид идэж уух гээд ч юм уу, тойргийн ард түмний саналыг худалдаж авах гээд байгаа юм ерөөсөө байхгүй. Яг тэр хүмүүст тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд л энэ төсвүүдийг бид тавьдаг.

Тийм учраас үүнийгээ бодолцож үзээч ээ. Энэ саналаа нэг эргэж хараач ээ гэж саналыг оруулж байгаа гишүүдээс хүсэх байна.

О.Номинчимэг: Сүхбаатар Эрдэнэбат гишүүн горимын санал гаргасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4.1.3-д горимын санал Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлууд, хэлэлцэх дараалал, журмын талаар гарсан саналыг хэлнэ ээ гээд.

Өргөдлийн Байнгын хорооны ажлын албанаас дэгийн асуудлаар зөвлөхдөө хоёр хоногийн өмнө саналаа гаргасан. Саналаа яаж томьёолж оролцуулах дээр гишүүний өөрийнх нь горимын санал журамтай холбоотой учраас санал гаргах эрхтэй гэсэн энэ байр суурийг илэрхийллээ.

Тэгэхээр эхлээд горимын санал буюу С.Эрдэнэбат гишүүний гаргасан саналаар саяын уншсан 4 хуудас саналын томьёолол байгаа. Тийм ээ. Энэ саналын томьёоллыг жижиглэж тус тусад нь уншиж санал хураалгах асуудал дээр санал хураалт явуулах нь. Горимын саналаар. Санал хураалтдаа бэлдье.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн өөрийн гаргасан төсвийн төсөлд өгсөн саналыг нэг нэгээр нь нь санал хураалгах горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 14 гишүүнээс 5 гишүүн дэмжсэн буюу 35.7 хувь нь дэмжиж 64.3 хувь нь татгалзсан байна.

С.Эрдэнэбат гишүүний горимын санал дэмжигдсэнгүй.

С.Эрдэнэбат гишүүний өөрийн саналтай холбогдуулан гаргасан горимын санал дэмжигдээгүй учраас түрүүн протоколд уншиж танилцуулсан Сүхбаатарын Эрдэнэбат гишүүний зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана.

Бэлдэх билүү? Одоо шууд уу? Шууд санал хураах юм байна.

Түрүүн уншсан 4 хуудас урт саналын томьёоллыг дэмжье гэсэн саналын томьёоллоор, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Нийт гишүүдийн 28.6 хувь дэмжсэн тул санал дэмжигдсэнгүй.

Хоёрдугаар санал. Та бүхэнд уншиж танилцуулъя.

Боловсрол, Эрүүл мэнд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас бусад салбарын урсгал зардлыг 15 хувиар бууруулж, энэ эх үүсвэрээр ахмад настуудын тэтгэвэрийг 10 хувь дээр нэмэх 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг **567.0 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат.

Энэ саналтай холбоотой санал гаргасан гишүүн тайлбар тавих уу? С.Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэбат: Би түрүүнээс хойш л хэлээд байгаа юм. Энэ хоёр том суурь салбар. Тэгээд хэдэн ахмадууд хөөрхий тэгээд энэ сар гаруй ч энэ саналыг тавилаа. Тэгээд энэ дээр эх үүсвэр гаргая гэхээр бид сонголт л хийх ёстой. Тэгээд тойрог тойргийнхоо зовлонг жалга довныхоо үзлийн асуудлыг яриад байвал энэ парламентын үндсэн үзэл баримтлал чинь нэлээн эргэлзээтэй болох ийм л зүйл байна л даа.

Тийм учраас төсөв танахад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэхээр тэтгэвэр, тэтгэмж гээд өөрсдөө ордог, хөдөлмөр эрхлэлт гээд маш олон зардлууд ордог. Боловсролоос өөрөөс нь урсгал зардал танана гэх юм бол

хүүхдийн хоолны мөнгөнөөс авхуулаад бичиг хэрэглэл, ширээ сандал, жижиг сажиг засвар үйлчилгээ гээд эргээд боловсролын хэвийн үйл ажиллагаатай холбоотой учраас би бас энэ салбараас хасах хэрэггүй. Эрүүл мэндийн салбараас хасах гэхээр эм тариа руугаа орох асуудал болно.

Тэгээд энэ гурван салбараа үлдээгээд түрүүний манайхны хэлдэг шиг сайхан хөрөнгө оруулалтаа хасахгүй гэвэл урсгал руугаа л орно. Би уг нь хөрөнгө оруулалт дэмжигдсэн бол урсгалыг заавал 15 болгоод байх шаардлагагүй гэж бодсон юм.

Тийм учраас нэн шаардлагатай байж байгаа эх үүсвэр Засгийн газрын 830 тэрбум гэдэг бол одоогийн байгаа тэр хуульдаа ч тэр ахмадын тэтгэврийг 10-аас дээш хувь нэмсэн, ажилчид, эрүүл мэндийн салбар, боловсролын салбарын хүмүүсийн тавиад байгаа санал шаардлагад хаана ч хүрэхгүй л зүйл байгаа юм.

Тийм учраас энэ саналыг Та бүгд маань дэмжээд. Тэгээд ажлын хэсэг бол байгаа. Хамгийн гол нь ний нуугүй хэлэхэд ажлын хэсэг ажиллаад хийгээд өгөөч гэхээр ерөөсөө нэгдүгээрт оруулах ч үгүй юм. Хоёрдугаарт, яг л ийм аргаар миний төсвийг чи битгий хамгаалаарай, битгий хасуулаарай гээд л бие бие рүүгээ ярьсаар байгаад л нөгөө нэг цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж чинь эцсийн дүндээ байхгүй. Засгийн газар ч гэсэн шийдвэр гаргахад хүндрэл рүү аваачна. Их Хурлын гишүүд өөрсдөө ингээд байвал.

Тийм учраас ажлын хэсэг дээр дэмжигдээд явах юм бол яг ний нуугүй хэлэхэд тэр 15 хувь урсгал зардал хасна гэдэг бол бас амаргүй. Гэхдээ эргээд энэ дээр ажлын хэсэг дээр яригдаад, төсвийн хэлэлцүүлгийн дүн дээр нэг тоон дээр бид уулзана байна шүү дээ. Тэн дээр зүйл байх юм бол би магадгүй энэ саналыг буцаагаад татаж болно.

Тийм учраас энэ бол ахмадын тэтгэврийг 10 хувь дээр нэмэх нь доод тал нь 100 мянган төгрөг гээд нийтдээ 567.0 тэрбум төгрөг шаардлагатай байгаа. Үүнийгээ ийм байдлаар гаргая гэдэг саналыг хэлж байгаа юм.

Тийм учраас 600 мянган төгрөгийн тэтгэвэртэй ахмад 800 мянган төгрөг л болох л ийм санал байхгүй юу.

Тийм учраас энэ санал дээр Та бүгд маань дэмжиж өгөхийг хүсье.

О.Номинчимэг: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүний гаргасан саналтай холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нараас тайлбар хийх хүн байна уу? 1 номер. Л.Мөнхзул дарга. Нэр, албан тушаалаа хэлээд тайлбараа хэлээрэй. 1 номер.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул байна.

С.Эрдэнэбат гишүүний гаргасан саналтай холбоотойгоор нийт нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийг 10 хувиар нэмээд дахиад 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхэд нэмж шаардагдах зардал нь 567.0 тэрбум биш 867.8 тэрбум төгрөг байгааг анхаарч өгөхийг хүсье.

О.Номинчимэг: Тооцоолол дээр ийм байна гэдэг тайлбар байна. Тийм ээ? Санал хураах уу? Гишүүдээ дуудъя. Дуудаж байна уу? Гишүүд саналаа өгье. Ирцэд орсон гишүүд маань орж ирж саналаа өгье.

Ж.Батсуурь гишүүн горимын санал гаргая гэж байна. Ж.Батсуурь гишүүний микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Мэдээж эмч, багш нарын, цаашилбал төрийн үйлчилгээний салбарт ажиллаж байгаа хүмүүсийн цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх нь тодорхой. Нэмэх ч ёстой.

Гэхдээ ийм аргаар явахгүй ээ. Өнөөдөр эрх барьж байгаа нам бүлгээ хуралдуул, улс төрийн шийдвэр гаргаач. Тэгэхгүйгээр энэ олон жилийн судалгаа тооцоотой явж байгаа хөрөнгө оруулалтыг зүгээр сэлэм бариад цавчаад цавчаад, чигээрээ явж байгаа төсвийн байгууллагуудыг шууд тэдэн хувиар, эдэн хувиар гээд буу шийдэм тулгаад хол явахгүй.

Та нар 2016 оноос хойш 10 дахь жилдээ засаглаж байна. Анх л...

О.Номинчимэг: Горимын саналаа гаргая. Ж.Батсуурь сайд аа.

Ж.Батсуурь: Горимын саналаа гаргах гэж байна. Горимын саналаа гаргах гэж байна.

О.Номинчимэг: Танд үг хэлэх, тайлбар хийх ямар нэгэн дэг байхгүй. Горимын саналаа л хэл. Одоо тэгээд хаана хаанаа хууль дүрэм журмаа баримталж баймаар байна.

Гишүүд ээ санал хураалтдаа бэлдээрэй.

Боловсрол, Эрүүл мэнд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас бусад салбарын урсгал зардлыг 15 хувиар бууруулж, энэ эх үүсвэрээр ахмад настнуудын тэтгэвэрийг 10 хувь дээр нэмэх 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг **567.0 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Санал хураалт. /алх цохив/ Дэмжье гэсэн саналын томьёоллоор.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 64.3 хувиар санал дэмжигдлээ.

Гуравдугаар санал. Бүх төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлыг 2 хувь буюу **770,000.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудын цалинг 50 хувиар нэмэхээр тооцож Эрүүл мэндийн сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа. Д.Ганмаа гишүүн саналаа тайлбарлая. Д.Ганмаа гишүүний микрофон.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Бүгдээрээ.

Бүх яамдын төлөөллүүд бараг байна. Бид ер нь үүнийг цөмөөрөө гурав, дөрвөн долоо хоногийн өмнө 9 сарын 21-нд хэлэлцсэн асуудал байгаа юм. Өргөдлийн байнгын хороонд. Тийм ээ.

Асуудал юу байсан бэ гэхээр Монгол Улсын бараг өнцөг булан болгонд амьдарч байгаа багаасаа эхлээд балчраасаа авхуулаад настан хүртэл буюу хамгийн бага нь 18 настай, хамгийн настай нь 81 настай хүмүүсийн төлөөллүүд аймаг тус бүрээс ирсэн санал. Энэ саналын дундаж нас нь 35 буюу ид яг ажил хөдөлмөр эрхэлж байгаа идэвхтэй насны хүмүүс байгаа.

Эдгээр хүмүүсээс ерөөсөө эмч, багш нарын цалинг нэмье гэдэг ганц л хүсэл бид нарт ирсэн. Өргөдлийн байнгын хорооны бараг анхны авч хэлэлцсэн асуудал. Тийм ээ.

Хоёрдугаарт, үүнтэй холбоотой асуудлуудыг Өргөдлийн байнгын хороогоор хэлэлцээд ерөөсөө байгаа бүх гишүүд бүгд бүгдээрээ дэмжиж саналыг хураалгасан.

Гуравдугаарт, ер нь эмч, багш нарын цалин үндсэн цалин нь хэд байдаг юм, нийт явагдаад байгаа цалингийн дээд хэмжээ нь хэд юм, бага хэмжээ нь хэд юм. Үндсэн цалингаараа амьдрах үнэхээр боломжгүй байна гэдгийг сүүлийн гурван долоо хоног бид хаана хаанаа зөндөө хэлэлцлээ.

Энэ асуудал дээр яг өмнө би нэг жилийн өмнө дөнгөж шинэ гишүүн болж орж ирээд бас төсвийн тал дээр, төсвийн нөгөө тэнцэл гэх үү дээ, Эрүүл мэндийн даатгалын төсвийн тэнцэл 280 тэрбумын дутагдалтай байхад 5 хувь бүх салбаруудаас хасаад үүнийгээ нэг байдлаар татаасаар оруулъя. Тэгээд энэ эмнэлгийн дутагдал болоод байгаа тусламж, үйлчилгээ, нас баралтын

асуудлууд, эмчилгээний асуудлуудыг шийдье гэсэн юм ярьсан боловч тухайн үед дэмжигдээгүй юм.

Яах вэ яагаад дэмжигдээгүй вэ гэхээр зэрэг маш олон юмнууд л ярьсан л даа. Урсгал зардал, төсвийн тогтвортой байдал, энээ тэрээ. Тэгэхдээ сая харж байхад засаг яг энэ асуудал дээр яг адилхан байдлаар төсвийн ерөнхийлөн захирагчдын хувийг бууруулаад үүнийгээ цалингаа нэмье гээд жилийн дараа яг ийм санал орж ирж байгаа юм.

Тэгээд ярьж байгаа юман дээр бүгдээрээ санал нэгдэж байгаа. Бид бүгдээрээ цалинг нэмье гээд Өргөдлийн байнгын хороогоор 100 хувь байсан хүмүүс нь санал нэгдээд гарсан. Байгаагүй нь яахгүй. Нөгөө дэмжээгүйгээр явсан л болохоос биш. Тэгээд 78 хувь гэж байгаа.

Үүнтэй холбоотой цөмөөрөө ерөөсөө энэ гарч байгаа зарчмын зөрүүтэй саналыг дэмжиж хэлсэн байна, хийсэнтэйгээ яг таарч байхаар Та бүхэнд уриалж байна. Гишүүд маань дэмжиж өгөх байх гэж найдаж байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан саналтай холбогдуулан Засгийн газраас тайлбар хийх хүн байна уу? Төсвийн ерөнхийлөн. 6 номер. Сангийн яам М.Санжаадорж дарга. 6 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Тайлбар хийе.

Д.Ганмаа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр нэгдүгээрт урсгал зардлыг 2 хувиар бууруулахад 770 тэрбум гарахгүй л дээ. Урсгал зардал өөрөө 22 их наяд байгаа.

Тэгэхээр тоо нь нэг дүгээрт өөрөөр гарна.

Хоёрдугаарт, яг түрүүний санал хурааж байгаагийнх нь эсрэг санал хураахаар байна л даа. Нэг талдаа тэтгэврээ нэмье гээд байдаг. Тэгээд энэ бол тэтгэврээсээ хасна.

Нөгөө талдаа төсвийн байгууллагуудын хувьд 9 хувиар орон тоог нь цомхотгоод зардал нь буурсан байгаа. Дахиад зардлыг нь хасаад байхаар галын машинууд маань гал гарч байхад шатахуунгүй гээд сууж байлтай нь биш. Эсвэл орон тоог нь цомхотгосон байхад дахиад хүнийгээ цомхотгох ч гэдэг юм уу ийм асуудал болоод.

Яах вэ, асуудлыг илүү том зургаар нь харах юм бол орлогодоо л бид хөтлөгдөөд байгаад байгаа шүү дээ. Орлого ямар байна. Нийт олж байгаа орлогодоо тааруулаад бид зарлагаа тавьж байгаа.

Одоо Их Хурал дээр нэгэнт өргөн барьсан төсөв зарлага дотроо хөдөлгөөн хийх л асуудал үлдээд байгаа юм. Яагаад гэхээр орлого автоматаар нэмэх боломжгүй. Санал гаргаад шууд 500 тэрбумаар нэмье гээд нэмдэг тийм зүйл биш. Хоёр, гурван байгууллага тооцоод гаргаад ирж байгаа юм.

Энэ бол өөрөө төсөвт байгууллагууд дээр нэлээн л хүндрэлтэй л юм руу л очно доо. Түрүүний нэмье гэж байгаа зүйлүүдээсээ ингээд зүгээр хувилж хасаад байхаар.

Гөгөө талдаа тооцоолол зарлага бол дандаа тоон дээр суурилдаг. Хэдэн хүн ажиллаж байгаа, ямар хэмжээний ажил гүйцэтгэж байгаа гэх мэтээр. Тэгээд хүрэх үр дүнгүүд маань энэ тоог хассантай холбоотойгоор өөрчлөх үү гэдэг бас нэг асуулт гарч ирнэ.

Зорилго, зорилтууд маань хүрэхгүй болж таарна. Яг үүнтэй холбоотойгоор. Тэгээд жилийн төсөвтэй хамт батлагддаг жилийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдээс гадна Засгийн газрын 4 жилийн хөтөлбөр яах вэ, 5 жилийн төлөвлөгөө яах вэ гээд ийм зүйлүүд гарч ирэхээр байна.

Тэгэхээр зүгээр том зургаар нь харвал бид орлогодоо л илүү анхаарал хандуулах нь зүйтэй юм шүү л гэж хэлье. Баярлалаа.

О.Номинчимэг: Ж.Батсуурь гишүүний микрофоныг өгье. Асуулт асуух юм байна.

Ж.Батсуурь: Бид асуудлыг ул суурьтай авч хэлэлцмээр байна. Энэ бүтэхгүй ээ.

Та нар хүмүүсийг шилний цаанаас чихэр горьдоолгоно гэдэг шиг ийм байдлаар явж болохгүй. Энэ чинь зүгээр далайн дээрэмчин шиг харагдаж байна шүү дээ. Та нар. Далайн дээрэмчид шиг харагдаж байна шүү дээ.

Төсвөө бод. Сая Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга чинь хэлсэн. Орлого нэмэх боломж байна. Бортээг. Ямар тээг. Яасан ийсэн гэнэ үү. Тэр мэрээ бодоод. Тэгээд нийгмийн халамжийн асуудлуудаа ярь.

200 гаруй хуулиар баталгаажуулаад нийгмээр дүүрэн халамж өгч байгаа. Тэрийгээ зөв юм уу, буруу юм уу гээд. Нөгөө 2016-2020 он, 2020-2024 он, 2024-2028 оныхоо мөрийн хөтөлбөрийг, хөгжлийн хөтөлбөрийг ингээд улс төрийн шийдвэрээ гаргаж наад эх үүсвэрээ, орлого талаа нэмээд, зарлага талаа асуудлаа гаргаж ирэхгүйгээр зүгээр надад өргөдөл ирсэн юм.

Энэ талд нь мэдээж багш нар цалингаа нэмүүлэхийг хүсэж байгаа. Энэ талд нь тэтгэврээ нэмүүлэхийг хүсэж байгаа. Энэ талд нь эмч нар цалингаа нэмүүлэхийг хүсэж байгаа.

Энэ дээр зүгээр тоглолт хийгээд шал худлаагаасаа телевизийн өмнө иймийг яах гэсэн чинь тэр хүмүүс татгалзлаа, энэ хүмүүс татгалзлаа гээд ингээд энэ цалин нэмэгдэхгүй.

Та нар үнэхээр эрх барьж байгаа нам юм бол үнэхээр тэр. Нөгөө талд нь хөрөнгө оруулалтаа хасна гэдэг чинь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөө бүгдийг үгүйсгэнэ л гэсэн үг шүү дээ.

Нэг мөрийн хөтөлбөр чинь биелэхгүй байгаа бол. Одоо ер нь биелж байгаа ч юм байхгүй байгаа. Тэгээд бүр бүгдийг биелүүлэхгүй болох юм уу.

Бусад салбар нь дуусаж байгаа бол бүгдийг дуусгая гэсэн байр сууриас хандаж болохгүй. Энэ чинь Төсвийн байгууллагын хороо, нөгөө Эдийн засгийн Байнгын хороо, улсын ерөнхий төлөвлөгөө, 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө энэ тэртэйгээ дүйцэхгүй байна шүү дээ.

Тэгээд үг хэлэх гэхээр үг өгөхгүй байна. Асуулт хэлэхээр асуулт өгөхгүй байна. Тэгээд шал дэмий 30, 40 төрийн албан хаагчдыг өдөржин хориод 10, 20 хуудас юм уншаад. Тэгээд үр дүн нь юу юм. Дэмжихгүй л гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр асуудлаа ул суурьтай нь авч үзэх хэрэгтэй байна. Наад бүлэг дээрээ наад асуудлаа ороод улс төрийн шийдвэрүүдээ гаргаач дээ. Бусад юман дээр болохоор гаргаад тэр байтугай асуудлуудыг шийдээд байдаг. Тэгээд энд хөөрхий төрийн албан хаагч нарыг ч ажлыг нь хийлгэхгүй, гадаа сууж байгаа хүмүүсийг ч шилний цаанаас чихэр горьдуулаад л. Энэ жил өнөөдөр 500 тэрбумыг дайчлах гэж байгаа. Маргааш 800 тэрбумыг дайчлах гэж байгаа гээд.

Яг үнэндээ энэ чинь бүгдээрээ худлаа байхгүй юу. Ингэж бие биеийнхээ ажлыг үрж байснаас намын бүлэг дээрээ очоод улс төрийн шийдвэрээ гаргаад, тэр улс төрийн шийдвэрээ Төсвийн Байнгын хороо, Эдийн засгийн Байнгын хороо, Сангийн яамтайгаа яриад оруулж ирээч дээ.

Тэгэхгүй тэгээд далайн дээрэмчид шиг загнаад байх юм. Тэгээд наадах чинь улам л хурцадна шүү дээ. Хэн өөрийнхөө 4 жил, 5 жилийн боловсруулсан хөрөнгө оруулалтыг хэнээр хасуулж байдаг юм. Тийм зүйл ерөөсөө байж болохгүй. Тэр чинь нөгөө талдаа... /минут дуусав/

О.Номинчимэг: Ер нь хуралдаан бол бид дэгийнхээ дагуу явж байгаа. Улсын Их Хурлын гишүүд өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд мэдээж саналаа гаргах бүрэн эрхтэй. Үүнийг нь бид харин бодлогын хувьд зөв үү, үгүй юу гэдэг

шийдвэрийг хамтын шийдвэр гаргадаг Байнгын хороогоороо л сайн хэлэлцэж угаасаа шийдвэр гаргана.

Тэгэхээр гишүүд санал гаргах эрхтэй. Тэрийг нь бид нухацтай хэлэлцэх хэрэгтэй. Дэгийн тухай хуулийн дагуу санал гаргасан гишүүнээс тодруулга асуулт асуух боломжтой байгаа тул танд үг өгсөн байгаа шүү. Асуулт тавих микрофоныг өгсөн байгаа шүү гэдгийг хэлье.

Ингээд санал гаргасан гишүүн Д.Ганмаа гишүүн тайлбар хийе. Тийм ээ. Д.Ганмаа гишүүний микрофон.

Д.Ганмаа: Улсын Их Хурлын гишүүд төсөв дээр санал өгөх, ер нь ард түмэн бид нарыг юу гэж боддог вэ гэхээр төсвийг Улсын Их Хурлын гишүүд л мэднэ гэж боддог.

Яг үнэндээ Улсын Их Хурлын гишүүд төсвийг мэддэг ганц арга нь юу байдаг вэ гэхээр Засгийн газраас боогоод ороод ирсэн бүр PDF файл ч биш бүр жижигхэн имиж дээр бид ажилладаг.

Тэгж ажиллахдаа бид яаж төсөвт оролцож чаддаг вэ гэхээр зарчмын зөрүүтэй санал гэж л юм оруулах боломжтой. Зарчмын зөрүүтэй саналыг оруулахдаа бид яадаг вэ гэхээр бусад боогдсон, тавигдсан төсөв дээрээс тодорхой нэг хэмжээний мөнгийг нэмж хасаж энд тэндээс олон барин байж бусад гишүүд, тойрог дээр тавьсан гишүүд бүх асуудлуудыг ярилцаж, тэд нарын дургүйцэл зэвүүцэл ч гэсэн энд мэдээж хүрч л байгаа. Хүргэн байж гаргадаг нэг хэдэн. Тийм ээ. Тэрийгээ бид төсөв дээрээ оруулахаар яг тодорхой төгрөгтэй мөнгөтэй нь бүр харьцуулж оруулж ирдэг. Үүнийг бид жилд ганцхан удаа энэ эрхээ эдэлдэг. Ганцхан жилд энэ эрхээ эдлэх гэж оролдоход Улсын Их Хурлын гишүүдийн төсөв дээр өгөх саналыг хаана хаанаасаа ингэж дайрч нэгдүгээрт улс төржүүлж байна.

Хоёрдугаарт, засгаас ярьж байна.

Гуравдугаарт, ерөөсөө салбар яамдаас ч гэсэн өчнөөн асуудлуудыг үүсгэж гаргаж ирж байна. Тоо хэмжээ гэж яриад байгааг би Та нарын өгсөн энэ ном дээрээс чинь хавсралт 14, хавсралт 15 төсвийн ерөнхий захирагч нарын зардлаас гэдгээс чинь тооцоолж гаргаж ирсэн. Энэ нь зөв буруу биш байж магадгүй гэж бодоод Эрүүл мэндийн яамны сайдынх нь өөрийн өгсөн тодорхой хэмжээгээр нэмэхэд 181.0 тэрбум төгрөг байна гэдгийг тоон дээр нь тааруулж дахиж шалгаж үзсэн.

Гуравдугаарт, Сангийн яамны бас хэлтсийн даргатай. Өчигдөр М.Санжаадорж дарга өөрөө Та орж ирэх ёстой байсан. Өөрийнхөө дараагийн бодвол мэргэжлийнхээ хүнээр оруулж ирсэн. Түүнтэй чинь бас ярилцаж,

хэлэлцэж, тооцоог нь гаргасан. Энэ тухай болгонд нь би үндэслэлээ хэлсэн, тайлбараа хэлсэн, ярьсан, тохирсон.

Тэгэхээр энэ дээр сая Ж.Батсуурь гишүүний яриад байгаа, яах вэ над руу хандаагүй л байх л даа. Ганц удаа ярих боломж гарсан дээр ярьсан байх гэж бодож байна. Энэ дээр попроод, чихэр долоолгоод болохгүй юмыг болгох гэж байгаа юм шиг царайлаад байгаа юм ерөөсөө алга.

Сэтгэл зүй, итгэл үнэмшил, боломжийн тооцоо төлбөр дээрээ үндэслээд хийсэн.

Бас нэг миний зөв байсан гэдгийг энэ батлах юм юу вэ гэхээр Ерөнхий сайд өөрөө энэ асуудал үүссэний дараа төсвийн ерөнхийлөн захирагчдын тооцооноос 10 хувь жигд хасаад тэгээд цалин, тэтгэврийг нэмэх асуудал руу орж ирсэн.

Тэгэхээр энэ чинь засгаас ч гэсэн дэмжигдэж байгаа саналууд. Энэ тал дээр би ийм тайлбар л өгье дөө.

О.Номинчимэг: Саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт. Түрүүн саналын томьёоллыг уншсан. Тийм ээ. Танилцуулсан. Санал хураалт гишүүд ээ.

Гуравдугаар санал хураалт.

Бүх төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлыг 2 хувь буюу **770,000.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудын цалинг 50 хувиар нэмэхээр тооцож Эрүүл мэндийн сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа. Санал хураалт. /алх цохив/

Нийт оролцсон гишүүдийн 57.1 хувь дэмжсэн тул санал дэмжигдлээ.

Дөрөвдүгээр зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

4.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 оны төсвийн жилд хэрэгжих хөрөнгө оруулалтын нийт зардал болох **3,267,3 тэрбум** төгрөг, Гадаад зээлийн ашиглалтын нийт зардал болох **1,542.4 тэрбум** төгрөгийн санхүүжилтийг бууруулах буюу 2026 онд шинээр баригдах сургуулиас бусад бүх барилгын хөрөнгө оруулалтыг тэвчиж нийт **301,066.0 сая** төгрөгөөр Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсөвт төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийн орлого **355,203.1**

сая төгрөг байсныг **301,066,7 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэлийн хувь хэмжээг **3%** болгож нэмэгдүүлэн 2026 оны эрүүл мэндийн даатгалын сангийн төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийн орлого **431,181.3 сая** төгрөгийг **732,848.3 сая** төгрөг болгох.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа, Сүхбаатарын Эрдэнэбат гэнэ.

Саналаа тайлбарлах уу? Эсвэл шууд асуултаар явах юм уу? Тайлбарлуулъя. Д.Ганмаа гишүүн тайлбарлая.

Д.Ганмаа: Тайлбар хэлье. Гишүүд ээ, бид хэд бас л Өргөдлийн байнгын хороогоороо ахиад л гурван долоо хоног хагасын өмнө ярьж байсан юм. Хөрөнгө оруулалтын зардлуудын би нөгөө листийг гаргаж бүгдэд нь тавьсан. Тийм ээ. Цөмөөрөө харсан шүү дээ.

Хөрөнгө оруулалтын зардал дээр хэд хэдэн асуудал байгаа юм. Нэгдүгээрт Азийн хөгжлийн банкнаас цөмөөрөө зээл аваад тэр зээлээрээ барилга бариад байгаа юм.

Тэгэхээр яадаг вэ гэхээр нөгөө урсгал зардал чинь 4, 5 жилийн дараа дахиад л нэмэгдэнэ. Дахиад л бид хүмүүсээ хэдэн төгрөгөөр цалинжуулах вэ, тоног төхөөрөмжөө яаж авах вэ гэдэг зардал чинь явах юм.

Дээрээс нь өчигдөр би Сангийн яамныхантай ярьж байхад бас надад тайлбарлаж байсан. Одоо энэ зээлийн төлөлт гэдэг чинь яалт ч үгүй төлөхөөс өөр аргагүй. Бид тэндээс нь төлөхгүйгээр нэг юм уу, жоохон хугацаа хойшлуулах юм бол дефолт зарлага эрсдэл рүүгээ орно.

Тэгэхээр бид зээл авах тусмаа зээлийн төлбөрийн асуудалд унана. Хэдийгээр бага ч байсан төлбөрөө төлөхгүй бол дефолт руу орно. Тэгээд макро эдийн засаг, энэ тэр гэдэг юмнууд чинь бүгд ингээд татагдаад явах юм.

Тэгэхээр гадаадын зээл, тусламжаар барилга, байшин барих, ер нь зээл, тусламжаар барилга, байшин барих өөрийн улсын төсвөөс барилга, байшин барихыгаа 2026 онд л зөвхөн тэвчье. Цөмөөрөө. Тэгснээрээ бид маш их.

Зүгээр би нэг жишээ гаргаад хэлье. Гадаадын зээл биш зөвхөн төсвөөс 2026 онд барилга, байшин барихгүйгээр хэмнэгдэх мөнгө нь юу вэ? Энэ дээр нөгөө засвар орж байгаа, тоног төхөөрөмж, энэ тэр бол зүгээр шүү. За юу. Энэ явдгаараа л явна. Хуучин баригдаад эхэлсэн юмнууд үргэлжилдгээрээ үргэлжилнэ. Зүгээр шинээр, цоо шинээр объект л ярьж байгаа юм.

Жишээлбэл, төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтаас нь Та хэдэд явуулснаас Онцгой байдлын ерөнхий газрынхыг хасаад, Хил хамгаалах ерөнхий газрынхыг хасаад, Зэвсэгт хүчин, Жанжин штаб, боловсролын салбарыг огт оруулахгүйгээр буюу нөгөө сургууль, цэцэрлэг, ясли бол баригдана гэсэн үг. 2026 онд шинээр баригдах барилга, байгууламжийн төсвийг харахаар нийт санхүүжих дүн нь 1.3 их наяд төгрөг.

Эндээс 2026 онд санхүүжих дүн нь зөвхөн улсын төсвөөс саяын объектуудыг хасаад 407.0 тэрбум төгрөгийг бид зөвхөн наад зах нь эндээс төсвөөс санхүүжилтээ нэмэх буюу үүнийг өөр зардалд зарцуулах бүрэн боломж байгаа юм.

Хоёрдугаарт, сая О.Номинчимэг даргын уншсанаар 3 хувь болгож нэмэгдүүлэх гэдэг асуудал юу яриад байгаа вэ гэхээр бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Тийм ээ. Төрөөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг заавал хариуцдаг 8 бүлэг байгаа. Тусламж, үйлчилгээний бас нэг тодорхой хэсгүүд байгаа. Эдгээрийг хувь хүнийхээ карман руу орохгүйгээр яг төрөөс гаргах ёстой санхүүжилтийг нь ганцхан хувиар нэмснээр бид бас мөнгө хэмнэх боломж нь бүрдээд байгаа юм.

Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр зэрэг боломжийн мөнгийг маш бага хувь ихэссэнээр саяын миний ярьсан эрүүл мэндийн даатгал, тусламж, үйлчилгээний зардалдаа нэмэх боломжтой байгаа юм.

Бид хэд ярьж байсан. Тийм ээ. Эмч, эмнэлгийн ажилчид өөрсдийнхөө хувцсаа өөрсдөө авч байна. Доор нь дэвсэх эмийн асуудал, тарианы асуудал, мөнгөө төлчхөөд дахиж нэмж улсын эмнэлгүүд чинь ерөнхийдөө хаалгаа барих гээд байна шүү дээ. Бүх эмч, эмнэлгийн ажилчид ярьж байгаа. Үүнийг олон хүн ярьж байгаа учраас би зүгээр давтаж ярихгүй. Гишүүдийг буюу энд ирсэн төрийн албаныхыг залхаахгүйн тулд товчилъё гэж бодож байна.

Эдгээр хоёр газраас мөнгө хэмнэснээрээ бид 301.0 тэрбум төгрөг авах боломжтой болоод байгаа юм. 301.0 тэрбумаар нөгөө эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төрөөс шүү. Төрөөс хариуцаж байгаагаа нэмэх боломжийг гаргах ийм санал юм.

О.Номинчимэг: Гаргасан саналтай холбогдуулан эхлээд Засгийн газрын тайлбарыг сонсох уу? Засгийн газрын тайлбар 6 номер. Сангийн яам. М.Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яам М.Санжаадорж.

Яг энэ саналтай холбоотойгоор тайлбар хийе.

Нэгдүгээрт, гадаад зээлийн ашиглалт гэдэг маань цаанаа зүгээр барилга барих гээд байгаа зүйл биш л дээ. Энэ нөгөө Эрдэнэбүрэнгийн дулааны цахилгаан станц байна, шатахуун хүндрэлтэй байна. Тийм ээ. Хомсдолтой байна. Шатахууны үйлдвэр байна гэх мэт ийм зүйлүүд ярих гээд. Нэгд нь яг юу хийх гэж байгаа талаас нь хэлэх юм бол.

Хоёрдугаарт, гадаад зээлийн зардлыг хасаад. Зээл байхгүй юу. Зээлийг хасаад бид цалин, тэтгэвэр, тэтгэмжээ нэмж, дээр нь эрүүл мэндийн үйлчилгээг санхүүжүүлж болохгүй хуультай. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр юу гээд заасан бэ гэхээр бид зөвхөн төсвийн орлогоор буюу олж байгаа татварын орлогынхоо хэмжээгээрээ бид энэ зардлаас санхүүжүүлдэг хуультай.

Тэгэхээр тэр хууль дээр зөрчил үүснэ. Гадаад зээлээс хассан ч гэсэн өөр зардал дээр тавьж болохгүй байхгүй юу. Өөрөөр хэлбэл зээл аваад бид цалин, тэтгэвэр, эрүүл мэндийн үйлчилгээг санхүүжүүлж болохгүй ийм хуультай.

Тэгэхээр энэ хуулийн зөрчил үүснэ.

Дараагийн ээлжид яг энэ ороод ирэхээр бид нөгөө төсвийн хүрээний мэдэгдлээ Их Хурал дээрээ хэлэлцээд гуравдугаар хэлэлцүүлэг маань явчхаад байгаа. Одоо ингээд удахгүй батлагдана. Төсвийн хүрээний мэдэгдэлдээ нийцсэн төсөв батлах ёстой. Улсын Их Хурал маань. Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийнх нь дагуу.

Тэгэхээр энэ маань өөрөө хүрээндээ нийцээгүй төсөв батлагдах эрсдэл үүсэх нь байна шүү. Алдагдлын тоо маань өөрчлөгдөх нь. Суурь зардал маань өөрчлөгдөх нь. Тийм ээ. Ийм зүйлүүд явах нь ээ л гэж л.

Түүнээс биш гишүүний гаргаж байгаа саналыг хүндэтгэж байна. Мэдээж хэрэг цалин хөлсийг нэмэх шаардлага байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэмэх шаардлага байна. Гол нь бид олж байгаа орлоготой хөнжлийнхөө хэрээр л байх болоод байгаа юм.

Нөгөө талдаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бас тайлбараа хийх нь зүйтэй байх. Цалингийн нэгдсэн бодлого гэдэг асуудал бид ярих ёстой. Эрүүл мэнд гэдэг салбартаа боловсролын салбарыгаа тэгвэл яах вэ гэдэг асуудал гарна. Соёлоо яах вэ, биеийн тамираа яах вэ. Тийм ээ. Гэх мэтээр ийм асуудлууд гарч ирэхээр байна гэж тайлбар хэлье. Баярлалаа.

О.Номинчимэг: Гаргасан саналтай холбогдуулан асуух гишүүд, тодруулах гишүүд байна уу? Нэрсээ өгчих. Гишүүдийн зүгээс бол. Дарсан юм

уу? Л.Рэгдэл гишүүн авах юм уу? Хэрэггүй юу? Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Энэ санал сайхан санал боловчиг гадаад зээлийн ашиглалтын нийт зардлаас мөнгө хасна гэдгийг чинь ойлгохгүй л байна л даа. Энэ чинь гадаадаас зээл аваад тэр гаргасан төсвөө яаралтай нөхөх хэмжээний тийм гадаад зээлээр санхүүжиж байгаа төслүүд байгаа шүү дээ. Том төслүүд байгаа шүү дээ. Жишээ нь, газрын тос боловсруулах үйлдвэр байна. Харин тийм. Би тэгээд энэ үйлдвэрийг барих, хянан шалгах ажлын хэсгийн ахлагч байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр би санал нийлэхгүй байгаа юм. Д.Ганмаа гишүүн энэ дээр яг Та бодитой тайлбар өгнө үү?

Дээрээс нь зөвхөн сургуулийн барилгыг үлдээж байгаа юм байна. Тийм үү? Тэвчиж болно гэж байна шүү дээ. Тэгээд эрүүл мэнд нь яах юм. Одоо манай тойрогт эрүүл мэндийн төв нь усанд автсан, тийм яаралтай засвартай, шаардлагатай тийм юм байгаа. Энэ ганцхан манай тойрог биш. Монгол Улсын хэмжээнд байгаа байх гэж бодож байна.

Сая Сангийн яамны тайлбар дээр энэ чинь хууль зөрчиж байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр үүнийг яаж зохицуулж байгаа юм?

О.Номинчимэг: Д.Ганмаа гишүүн хариулъя. Микрофоныг өгье.

Д.Ганмаа: Тийм. Яг зайлшгүй тодруулах хэрэгтэй юм байна. Бууруулах дүн 301.0 тэрбум. Нэмэх дүн нь мөн 301.0 тэрбум.

Энд миний бичсэн тоо бол нэр буюу нийт хаана хаана, ямар ямар мөнгө яваад байгаа гэдгийг нэрлэж байгаа юм. Түүнээс яг эд нараас буюу одоо жишээлбэл хууль зөрчин барин гадаадын зээлээс мөнгө аваад, тэрийгээ энэ талын тусламж, үйлчилгээний зардал руу оруулах тухай огт биш. Юу гэсэн үг вэ гэхээр ерөнхийд нь би энд бичсэнээр нийт бид нарт улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд 3.2 их наяд төгрөг гээд товчлоод уншъя. За юу. Гадаадын зээл болохоор 1.5 их наяд төгрөг байгаад байна.

Тэгэхээр ийм мөнгө төгрөг бид нарт бол ер нь байгаад байна гэсэн санаа. Тэгэхдээ энэ дотроос саяын ярьснаар ялангуяа Л.Мөнхбаясгалан гишүүний, ялангуяа тэр доор ус буцаалдаад байж байгаа эмнэлгийг бид говийнх болохоор бүгдээрээ хамт очиж үзэж яг энэ тухай ярьж байсан.

Нэгэнт баригдаад эхэлсэн барилга дээр тас ерөөсөө асуудал орохгүй. Тэр байрыг засах хэрэгтэй, засвар оруулах хэрэгтэй, дараа дараагийнх нь юмнуудыг оруулах хэрэгтэй.

Сургууль, цэцэрлэгийн хувьд яагаад хойшлуулах зайлшгүй, юу гэдэг юм шинээр баригдахыг хойшлуулж болохгүй гэж үзсэн бэ гэхээр гурваараа суугаад байгаа, тэр дотор ажиллаж байгаа багш нарын асуудал, цаг агаар, юу гэдэг билээ. Дотоод орчны бохирдлын асуудал, анхаарал төвлөрөлт, шуугиан, тэгээд нөгөө амьсгалын замын хурц халдварт өвчлөл, салхилалт үүсэж болохгүй энэ тэр гээд ярих юм бол зовлон их байгаа юм.

Тэгэхээр яах аргагүй сургууль, цэцэрлэгийг энд оруулаагүй. Зөвхөн 2026 онд шинээр эхлэх объектыг л гэсэн санаа юм. Энэ 301.0 тэрбум төгрөгийг бид хаанаас авах бүрэн боломж гараад байна гэхээр түрүүний миний хэлснээр төсвөөс баригдаж байгаа цоо шинэ 2026 онд эхлэх гэж байгаа барилгууд. Тэгэхдээ тэрийг тооцоод үзэхэд л гэхэд 421.0 тэрбум төгрөг гарч байна лээ. Эндээс бид зөвхөн 301.0 тэрбумыг нь ашиглаад, одоо тасалдаад байгаа эмнэлэг тусламж, үйлчилгээ, одоо нас баралтад хүрэх эрсдэлтэй том том өвчлөлүүд, одоо огт хэрэгжүүлж чадахгүй эмнэлэг тусламж, үйлчилгээнүүддээ л зарцуулъя гэсэн санаа байгаа юм. Хууль зөрчсөн асуудал энд байхгүй байгаа.

О.Номинчимэг: Тодруулъя. 1 минут. Л.Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан гишүүний микрофон. 1 минут.

Л.Мөнхбаясгалан: Гадаад зээлийн ашиглалтын нийт зардал 1.542.4 тэрбум гэж байна шүү дээ. 4 тэрбум. Би бол энэ дээр эсрэг саналтай байгаа байхгүй юу. Гадаад зээлийн ашиглалтыг бид нэмэгдүүлэх ёстой байхгүй юу даа. Тийм хуулийн төсөл өргөн бариад явж байгаа. Бид гадаадын зээл ашиглалтаа багасгаж танах биш нэмэх ёстой. Бүр хуулиа өөрчлөөд нэмэх ёстой байхгүй юу. Гарцаагүй уучлаарай.

Тэгэхээр энэ дээр эрхэм гишүүд бас бодолцох хэрэгтэй. Бид нэгэнт зээл авсан. Зээлийн зарцуулалтаа бүр нэмэх ёстой болохоос биш хасах ёсгүй ээ.

Тийм учраас энэ дээр уучлаарай эсрэг саналтай байна. Санал хураалтдаа бодолцоорой.

О.Номинчимэг: Д.Ганмаа гишүүн тодруулах 1 минут.

Д.Ганмаа: Энэ бодвол би л буруу бичсэн байх л даа. Энэ гадаад зээлээс огт мөнгө авахгүй. Ашиглалтыг өөр юманд зарцуулахгүй.

Зүгээр ер нь гадаад зээлд бид 1.5 их наяд төгрөг байна л гэж бичиж байгаа юм. Үндэслэл маягаар бичиж байгаа байхгүй юу. Түүнээс гадаадын зээлийг ч, ашиглалтыг ч эндээс огт зарцуулахгүй, оролдохгүй, хүрэхгүй. Тэндээс мөнгө хасахгүй шүү. Үүнийг маш тодорхой болгоё, засъя.

Тэгье. Тэгье. Саналаа татъя даа. Юу ч гэсэн С.Эрдэнэбат гишүүн тайлбарлах юм уу.

О.Номинчимэг: Д.Ганмаа гишүүн горимын санал гаргая гэж байна. Д.Ганмаа гишүүний микрофон.

Д.Ганмаа: Би энэ саналаа татаад авъя. Тэгээд засваруудыг оруулъя. Тэгэхгүй бол жоохон буруу зөрүү ойлгогдохоор томъёолоод оруулж ирсэн байна. Уучлаарай.

О.Номинчимэг: Д.Ганмаа гишүүн өөрийн гаргасан саналаа татлаа. Ер нь дараагийн саналаа гаргахдаа ч гэсэн хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэлийн хувь хэмжээг 3 хувь болгож нэмэгдүүлж гэж зарчмын зөрүүтэй саналаар оруулах нь хуулийн зөрчил ер нь үүсгэж маш том асуудал болохоор л харагдаж байна.

Тэгэхээр үүнийг бас анхаарч тэр дараа дараагийн саналыг гаргах байх гэсэн бас байр сууриа илэрхийлье.

Саналаа татсан учир дараагийн санал руу оруулъя.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Их Хурлын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “2.1.1.1 Хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байна.” гэх дэд заалтыг хасах;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Жудагийн Баярмаа, Дуламын Бум-Очир, Жанчивын Галбадрах, Даваасамбуугийн Ганмаа, Батбаярын Жаргалан, Жаргалсайханы Золжаргал, Б.Мөнхсоёл гишүүн, А.Ундраа гишүүн, Б.Пунсалмаа гишүүн, О.Саранчулуун гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Д.Энхтүвшин гишүүн гэсэн. Энэ саналыг гаргасан байна.

Саналаа тайлбарлах уу? Г.Лувсанжамц гишүүний микрофон.

Г.Лувсанжамц: Товчхон тайлбарлая. Эндээс хойших саналууд бүгдээрээ төсөв, мөнгөний ямар ч агуулга байхгүй.

Төсвийн 1 дүгээр хавсралт буюу

- ▶ шалгуур үзүүлэлтийн буруу орж ирсэн юмнуудыг нь засаж байгаа,
- ▶ байхгүй юмнуудыг нь нэмж байгаа,
- ▶ шаардлагагүй зүйлүүдийг нь хасаж байгаа

гэсэн гуравхан төрлийн л саналууд байгаа.

Ямар ч төсвийн урсгал зардал ч юм уу, хөрөнгө оруулалтын зардал хөндөөгүй байгаа. Тэгээд 48 санал байгаа учраас хэдүүлээ Та бүхэн дэмжээд өгөх юм бол тайлбарлах шаардлагагүйгээр саналаа хураад явъя гэж бодож байна. Баярлалаа. Дэмжиж өгөхийг хүсье.

О.Номинчимэг: Г.Лувсанжамц гишүүн тайлбар хэлье.

Г.Лувсанжамц: Төсвийн 1 дүгээр хавсралт бол урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардлаараа хүрэх гэж байгаа зорилт болон шалгуур үзүүлэлтүүд байгаа.

Тэгээд одоо ямар түвшинд байгаа, ямар түвшинд очих гэж байгаа вэ гэдгийг нь бичсэн байгаа. Гэтэл энэ дээр алдаатай зүйлүүд маш их байгаа. Өмнө нь би бас хэлж байсан. Эрчим хүчний яам жишээ нь эрчим хүчийг “ватт” биш “километр”-ээр хэмжсэн байсан ч юм уу. Тийм ээ. Тийм заалтуудыг нь засаж оруулж ирж байгаа гэсэн үг.

Энгийнээр хэлэх юм бол “би турна гэсэн зорилт тавьчихаад шалгуур үзүүлэлт нь “гум”-д явсан тоогоороо хэмжинэ” гэж байгаа юм. Үгүй ээ. Таны хэр турсныг килограммаар л хэмжинэ шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр яг тиймэрхүү алдаатай зүйлүүд байгаа. Тэгээд жишээлбэл энэ 5 дугаар санал дээр “хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байна” гээд. Энэ угаасаа хууль дээр байж байгаа зүйлийг шалгуур үзүүлэлт болгож бичиж орж ирж байгаа гэсэн үг.

Тэгэхээр үүнийхээ оронд илүү үр дүнтэй шалгуур үзүүлэлтүүдийг тавья гээд 6 дугаар санал дээр нь Их Хурлын дарга дээр ойролцоогоор 7, 8 шалгуур үзүүлэлтийг нэмж өгч байгаа гэсэн үг.

Тэгэхээр одоо буруу... /минут дуусав/

О.Номинчимэг: Р.Эрдэнэбүрэн гишүүнээс тодруулъя. Асуулт асууя.

Р.Эрдэнэбүрэн: Өдрийн мэнд хүргэе.

Г.Лувсанжамц гишүүн ээ. Маш олон юунууд оруулсан байна. Ер нь уг нь зөв байх зарчмын хувьд. Тэгэхдээ нэгдүгээрт ийм шалгуур үзүүлэлтүүд өмнө нь байдаггүй байсан юм уу?

Хоёрдугаарт, Сангийн яамтай, санаачилж байгаа Засгийн газартай энэ бүх юмнуудаа ярьсан уу?

Гуравдугаарт, үнэхээр тийм алдаатай байвал ер нь бид цаашдаа Засгийн газрын цаас юман дээр нь бид Их Хурал зарчмын хувьд ажиллаад л засаад л Засгийн газрын ажлыг хийгээд байдаг юу бол биш шүү. Засгийн газрын өмнөөс ажиллаад байдаг.

Буцаагаад ийм алдаатай байна, ийм юм болохгүй байна гээд хэлээд ингээд өөрсдөөр нь засуулаад явдаг тийм юутай байх ёстой шүү гэсэн ийм гурван зүйл асууя. Эхлээд.

О.Номинчимэг: Г.Лувсанжамц гишүүн хариулъя.

Г.Лувсанжамц: 1 дүгээрт төсвийн ерөнхийлөн захирагч маань ихэнхтэй нь уулзсан. Энэ 1 дүгээр хавсралтыг засаж байсан удаа бараг байхгүй юм билээ. Анх боловсруулсан тэр чигээрээ л жил болгоны төсвийг баталсаар ирсэн.

Хоёрдугаарт, 185 дугаар тогтоолын ажлын хэсэг байгаа. Энэ саналуудыг өргөн барьсан бүх гишүүд дотор нь байгаа. Сархадын Зулпхар гишүүн бас энэ ажлын хэсэгт байгаа.

Дэд ажлын хэсгүүд байгуулаад 100 гаруй төрийн албан хаагчдыг бүх төсвийн ерөнхийлөн захирагч нараас дуудаад өнгөрсөн зуны амралтын хугацаанд юм уу. Тийм ээ. Бид нийтдээ 8 удаагийн хэлэлцүүлэг хийгээд танай шалгуур үзүүлэлт буруу байна. Үүнийг чинь заслаа. Та бүхэн саналаа өгөөрэй гэж хэлээд зөвшилцсөний үндсэн дээр оруулж ирж байгаа саналууд.

Түүн дээрээсээ байж болох саналуудыг нь авсан гэсэн үг.

Гуравдугаарт, таны хэлж байгаа түмэн зөв. Уг нь Сангийн яам ч юм уу, Эдийн засаг, хөгжлийн яам, төсвийн ерөнхийлөн захирагч нараас орж ирж байгаа шалгуур үзүүлэлтийг буруу байх юм бол буцааж байх ёстой.

Тэгээд буцаагаагүй жил болгон батлагдаад ирсэн юмыг нь энэ 185 дугаар тогтоолын ажлын хэсгээрээ гаргаад бид төсвийн 1 дүгээр хавсралт, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний 2 дугаар хавсралт, 5 жилийн чиглэл, 4 жилийн хөтөлбөр, “Алсын хараа-2050”-ийн энэ хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг бүгдийг нь засаж байгаа ажлыг 185 дугаар тогтоолын ажлын хэсэг дээр хийж байгаа.

Тэгэхээр эхний удаад бид энэ жилийнхээ төсвийгээ засъя. Дараа нь бид хуулийн төсөл өргөн барихдаа сая хэлсэн бүх бодлогын бичиг баримтуудын бүх шалгуур үзүүлэлтийг нь энэ дээрээ үндэслээд засаад явна гэсэн төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байгаа.

О.Номинчимэг: 6 номер. Сангийн яам. Эдийн засаг, хөгжлийн яамыг бас дуудаарай. Шалгуур үзүүлэлттэй холбоотой. Эрхэлсэн яам нь тэнд байгаа шүү. 6 номерын микрофон Сангийн яам, М.Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээр асуултыг засаж сайжруулж байгаа асуудлыг Сангийн яамнаас 100 хувь дэмжиж байгаа. Энэ нь зүйтэй.

Хоёр дахь асуудлын хувьд энэ яах вэ Засгийн газрын хувьд Үндсэн хуулиар заасан бүрэн эрхийнх нь дагуу төсвийн төслийг нэгтгэн ирүүлж байгаа. Яг энэ хурааж байгаа санал жишээ нь Улсын Их Хурлын хүрэх үр дүн болоод байгаа юм.

Энэ дээр юу гээд заасан байна гэхээр зүгээр хууль дээр хийх ёстой зүйлээ л бичээд үүнийг хангасан гэдгийгээ яаж үнэлэх вэ, одоо хангагдахгүй байгаа ч юм уу ийм асуудлууд байгаа учраас ирэх жилийн төсөвтөө тааруулж тухайн аль ч байгууллагын хувьд тухайн салбарыг хариуцсан сайд нарын хувьд зорилго, зорилт гэж байдаг. Урт хугацааны.

Дунд хугацаанд хийх зүйл. Үүнийгээ нэг жилийн дотор ирэх жил хэд байгаа үзүүлэлтийг яаж сайжруулах л асуудал яригдаад байгаа юм. Тэгээд энэ асуудлуудаа сайжруулж байгаа асуудал учраас бид дэмжиж байгаа.

Бид нэгтгэж оруулж ирдгээс биш тухайн байгууллагыг хүчээр ийм юм хий гэж шахаж оруулж ирдэггүй.

О.Номинчимэг: Р.Эрдэнэбүрэн гишүүн тодруулъя.

Р.Эрдэнэбүрэн: Сангийн яам тэгээд ороод ирснийх нь дараа үүнийг дэмжье гэж байгаа юм байна.

Тэгэхээр өмнө нь оруулж ирэхдээ залхуурсан юм уу, эсвэл ямар шалтгаанаар ийм байдлаар оруулж ирээд тэгээд Г.Лувсанжамц гишүүн засаад явж байгаа юм бэ гэдгийг нь мэдвэл.

Ер нь яах вэ, би тэр тооцоолол, янз бүрийн юмаа сайжруулах, шинжлэх ухаанч болгох гэдэг дээр нь дэмжиж байгаа юм. Тэгэхдээ яагаад анхнаасаа ингэж яваагүй юм бэ гэдгийг л сонирхоод байгаа юм.

О.Номинчимэг: 6 номер Сангийн яам. М.Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Төсвийн төслийг 7 сарын 25-нд Сангийн яаманд саналаа ирүүлж байгаа. Тэгэхдээ энэ 1 дүгээр хавсралт буюу шалгуур үзүүлэлтүүдээ ирүүлж байгаа юм.

Гэхдээ жишээ нь Их Хурал өөрөө төсвийн төслөө олон нийтээр хэлэлцүүлээд, бүх зорилго, зорилтуудаа үзүүлээд ингээд ороод ирсэн зүйл дээр бид төсөв талаас нь буюу орлогодоо нийцүүлсэн байдлаар бид зарлагыг нь хянаж байгаагаас биш 1 дүгээр хавсралтын хүрэх үр дүнг Сангийн яам төдийлөн шахах нь өөрөө зохимжгүй болоод байгаа юм.

Их Хурлын Тамгын газрын даргын гарын үсэгтэй бичгээр ирсэн зүйлийг бид үгүй ээ, таны хийх гэж байгаа зүйл буруу байна гэж хэлэх боломжгүй болоод байгаа юм л даа.

Тэгэхээр үүнийг хаа нэг газар засах ёстой. Түүнд Р.Эрдэнэбүрэн гишүүний хэлж байгаа саналтай 100 хувь санал нэг байна.

Энэ хэзээ засагдах ёстой вэ гэхээр бидний бодлоор уг нь өмнөх тодотгол дээр бид оруулж ирсэн. Жишээ нь, 1 дүгээр хавсралтыг нь гүйцэтгэлтэй нь хамт хянадаг больё. Тэгж байж төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрсдөө төсөвтөө хариуцлагатай больё гэдэг санал орж ирсэн. Харамсалтай нь батлагдаагүй.

Эдийн засаг, хөгжлийн яам бас үүнийг... /минут дуусав/

О.Номинчимэг: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Нэгэнт холбогдох яамд талархалтайгаар хүлээн авч байгаа бол, тэгээд маш их ажилласан тийм ажил хэрэгч байдлаар маш их хөдөлмөр зарцуулсан харагдаж байна. Нэг саналаар хурааж өгнө үү.

О.Номинчимэг: Горимын санал юм уу? Тийм ээ. Ийм ийм байна. Сая бид бас асуулаа. Тэгээд багцлаад төсвийн ерөнхийлөн захирагч болгоноор нь багцалсан юм байна. Энэ бүгд нь нийлэх юм бол энэ чинь өөрөө хорин хэдэн хуудас санал. Дээр нь төсвийн төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр биш болохоор дэг зөрчих эрсдэлтэй юм байна.

Тэгэхээр боломжгүй юм байна гэж. Тэгвэл санал хураалтаа явуулъя. Тэгэх үү? Санал хураалтаа сайхан хийж, цөмөөрөө юу яая.

Одоо ерөөсөө уншаад юу яагаад явъя тэгэх үү? Санал хураалт.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Их Хурлын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 2.1.1.1 хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байна гэх дэд заалтыг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын 15 гишүүн санал хураая. /алх цохив/

Гишүүдийн 78.6 хувь нь дэмжсэн тул санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Их Хурлын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “2.1.1.2 Хүний эрхийг хангах чиглэлээр баталсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%.” гэсэн дэд заалт, “2.1.1.3 ОУ-ын гэрээ, конвенцийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “2.1.1.4 Хүний эрх, жендэрийн асуудлаарх парламентийн өөрийн үнэлгээний хэрэгжилт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 48.3, Зорилтот түвшин: 50.7” гэсэн дэд заалт, “2.1.1.5 Шийдвэр гаргалт нь олон нийтийн оролцоотой, иргэдийн санаа бодлыг тусгасан үр дүнтэй гэдэгт итгэдэг хүн амын эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 48.3, Зорилтот түвшин: 50.7” гэсэн дэд заалт, “2.1.1.6 Хууль, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийн тоо буурсан хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц нарын 15 гишүүн. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн буюу 78.6 хувь дэмжсэн тул санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр хавсралтын Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “4.1.1.1 Хяналтын шатны журмаар шийдвэрлэгдэж буй хэргийн дундаж хугацаа /бууруулах/ Хэмжих нэгж: Хоног, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт, “4.1.1.2 Хууль хэрэглээний нэгдмэл байдлын түвшин. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2023, Суурь түвшин: 67.8, Зорилтот түвшин: 70” гэсэн дэд заалт, “4.1.1.3 Хууль тогтоомжийг боловсронгуй болгохоор боловсруулж хүргүүлсэн санал. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 3, Зорилтот түвшин: 6”, “4.1.1.4 Судалгааны чанарыг дээшлүүлэх арга хэмжээ. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 0, Зорилтот түвшин: 1” гэсэн дэд заалт, “4.1.1.5 Шүүхийн цахимжилт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2023, Суурь түвшин: 76.4, Зорилтот түвшин: 79” гэсэн дэд заалт, “4.1.1.6 Шүүхийн шийдвэрийн нээлттэй, ил тод байдал. Хэмжих нэгж: Хоног, Суурь он: 2024, Суурь түвшин: 22.7, Зорилтот түвшин: 20” гэсэн дэд заалт, “4.1.1.7 Шүүн таслах ажиллагаанд оролцоход шаардлагатай хүртээмжийн үйлчилгээ хүссэн иргэдэд эзлэх

үйлчилгээ авч чадсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “4.1.1.8 Хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн талаарх мэдээллийг тэгш хүртээмжтэй (дохионы хэлмэрч, хадмал орчуулга зээг хүртээмж) олон нийтэд мэдээлсэн мэдээллийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 0, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “4.1.1.9 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрхийг хангасан арга хэмжээ. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10” гэсэн дэд заалт, “4.1.1.10 Шүүхийн шийдвэрийг ойлгомжтой байлгах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ (шүүхийн шийдвэрийн тойм, хураангуй бичсэн тоо ба нийт шийдвэрийн харьцаа, олон нийтэд нээлттэй мэдээлсэн байдал). Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “4.1.1.11 Давж заалдах тогтолцооны үр нөлөө (хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн үндэслэл). Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10” гэсэн дэд заалт, “4.1.1.12 Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-д заасан арга хэмжээний хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц нарын 15 гишүүн. Санал тайлбар байхгүй бол санал хураалт. /алх цохив/

Нийт 11 гишүүн буюу 78.6 хувь нь дэмжсэн тул санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “5.1.1.2 Бүх шатны шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацааг бууруулах, Хэмжих нэгж: Хоног, Суурь он: Т, Суурь түвшин “Т-10%”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт, “5.1.1.3 Иргэдэд ээлтэй үйлчилгээний орчин бүрдүүлсэн шүүхийн тамгын газрын эзлэх хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: Т, Суурь түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “5.1.1.4 Анхан шатанд шийдвэрлэгдэж буй хэргийн дундаж хугацааг бууруулсан байдал. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “5.1.1.5 Давж заалдах шатанд шийдвэрлэгдэж буй хэргийн дундаж хугацааг бууруулсан байдал, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: Т, Суурь түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт, “5.1.1.6 Шүүхийн үр ашигт байдлын индекс. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “Хянан шийдвэрлэсэн хэргийн талаарх мэдээллийг тэгш хүртээмжтэй (дохионы хэлмэрч, хадмал орчуулга зээг хүртээмж) олон нийтэд мэдээлсэн мэдээллийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 0, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “5.1.1.7 Тухайн жилд олон нийтэд мэдээлсэн шүүхийн шийдвэрийн тойм, хураангуй. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 0, Зорилтот түвшин: Т+10” гэсэн дэд заалт, “5.1.1.8 Шүүгч гаргасан шийдвэрийнхээ талаар иргэд, олон нийтэд нээлттэй мэдээллэсэн байдал (нийт мэдээлэлд эзлэх хувь). Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь

түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “5.1.1.9 Шүүн таслах ажиллагаанд оролцоход шаардлагатай хүртээмжийн үйлчилгээ хүссэн иргэдэд эзлэх үйлчилгээ авч чадсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “5.1.1.10 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрхийг хангасан арга хэмжээ. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10” гэсэн дэд заалт, “5.1.1.11 Цахим системийн хөгжүүлэлт/Шүүхийн цахимжилт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-д заасан арга хэмжээний хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “5.1.1.17 Олон улсын гэрээ, конвенцын болон НҮБ-ын хүний эрхийн хороодуудаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “5.1.2 Шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангана” гэсэн заалт, “5.1.2.1 Шүүхийн индекс. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2023, Суурь түвшин: 53.22, Зорилтот түвшин: 65” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц нарын 15 гишүүн. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн буюу 71.4 хувь дэмжсэн тул санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр хавсралтын Шүүхийн сахилгын хорооны даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “6.1.1.2 Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг хүчингүй болгосон тохиолдлын эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 14.8, Зорилтот түвшин: 14”, “6.1.1.3 Өргөдөл, мэдээллийг хянан шийдвэрлэх дундаж хугацааг бууруулсан байдал. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “6.1.1.4 Шүүгчийн ёс зүй ба хариуцлагын индекс. Хэмжих нэгж: Оноо, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “6.1.1.5 Үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын индекс. Хэмжих нэгж: Оноо, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “6.1.1.6 Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахимжилт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 73, Зорилтот түвшин: 85” гэсэн дэд заалт, “6.1.1.7 Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдал. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 96.5, Зорилтот түвшин: 97” гэсэн дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд.

Энэ редакц, найруулга дээр хараарай. Зарим нь “хувь” гэсэн мөртлөө “оноо”-гоор явж байгаа юмнууд байна шүү. Хооронд нь хольж сольсон юм байх шүү. Санал хураах уу? Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн буюу 78.6 хувь дэмжсэн тул санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр хавсралтын Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “7.1.9 Хүний эрхийн зөрчлийн тоог бууруулж, иргэдийн эрхийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх.” гэсэн заалт, “7.1.9.1 Хүний эрхийн зөрчлийн тоо өмнөх онтой харьцуулахад буурсан хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%”, “7.1.2.2 Гомдлыг шийдвэрлэж буй дундаж хугацааг бууруулсан байдал. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “7.1.2.3 Гомдол хүлээн авах ажиллагааг хялбаршуулах арга хэмжээ. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 0, Зорилтот түвшин: Т+10” гэсэн дэд заалт, “7.1.2.4 Зөрчигдсөн эрх сэргээсэн байдал (нийт гомдолд эзлэх хувь). Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “7.1.4.4 Комиссын зөвлөмж, гишүүний шаардлага, зөвлөмж хүргүүлж буй салбар, эрхийн зөрчлүүдийн ангилалд гарч буй өөрчлөлт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “7.1.5.2 Хүний эрх хамгаалагчийн өссөн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “7.1.5.3. Зорилтот бүлгийн иргэдийн хувийн мэдээлэл алдагдалт буурсан байдал. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “7.1.5.4 Ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой ирсэн өргөдөл, гомдлын мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “7.1.5.5 Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор бүх шатны боловсролын байгууллагын баталсан хөтөлбөрт гарсан өөрчлөлт (нийт хөтөлбөрт эзлэх хувь). Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “7.1.2.7 Өмнөх оны илтгэлийн мөрөөр Монгол Улсын Их Хурлаас гарсан тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлсэн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “7.1.2.8 Олон улсын гэрээ, конвенцын болон НҮБ-ын хүний эрхийн хороодуудаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц нарын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 1 дүгээр хавсралтын Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “7.1.2.1 Гомдол шийдвэрлэлт гэснийг “Хүний эрхийн зөрчлийн талаар ирсэн гомдлын бүрэн шийдвэрлэлт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “2024”, Суурь түвшин “Т”, Зорилтот түвшин “Т+10%” гэснийг гэж тус тус өөрчлөх. Тийм ээ.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсамжамц нарын гишүүд.
Санал хураалт. /алх цохив/

9 гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр хавсралтын Улсын ерөнхий прокурорын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “8.1.1 Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.” гэсэн заалтыг, “8.1.1.1 Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон эрүүгийн хэргийн хяналт, шийдвэрлэлтийн тайлан.” гэсэн дэд заалтыг, “8.1.2 Ял эдлүүлэх үйл ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавина.” гэсэн дэд заалтыг, “8.1.2.1 Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон цагдан хорих, баривчлах, саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу шалгалт, судалгаа хийх, танилцах ажиллагаа.” гэсэн дэд заалтыг, “8.1.3 Монгол Улсын хэмжээнд Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.” гэсэн заалтыг, “8.1.3.1 Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн зөрчил” гэсэн дэд заалтыг тус тус хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд.
Санал хураалт. /алх цохив/

Нийт 10 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 1 дүгээр хавсралтын Улсын ерөнхий прокурорын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “8.1.1 Эрүүгийн хэрэгт тавих хяналтын чанар, ял эдлүүлэх ажиллагаа, зөрчлийн шийдвэрлэлтийн хууль ёсны байдал.” гэсэн заалт, “8.1.1.1 Хууль бус хорих, саатуулах, баривчилгааны эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин:Т”, Зорилтот түвшин“Т-10%” гэсэн дэд заалт, “8.1.1.2 Ял эдлүүлэх ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгуулсан хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “8.1.1.3 Зөрчлийн хэрэг шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгуулах прокурорын хяналтын үр дүнгийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “8.1.2 Гэмт хэрэг, ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах, хууль бус баривчилгаа, хорих ажиллагааг бууруулах.” гэсэн заалт, “8.1.2.1 Хууль бусаар

хорих, баривчлах болон бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдлын эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт, “8.1.3 Шүүхийн шийдвэрийн хууль хэрэглээний нэг мөр байдлыг хангахад прокурорын хяналтын үүргийг хэрэгжүүлэх.” гэсэн заалт, “8.1.3.1 Шүүхээс прокурорын эсэргүүцлийг үндэслэн хүчингүй болгосон шийдвэрийн эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт, “8.1.4 Эрүүгийн хэрэгт тавих прокурорын хяналтын чанар сайжирч, шүүхээс буцаагдсан хэргийн тоо буурсан байх.” гэсэн заалт, “8.1.4.1 Шүүхээс буцаагдсан хэргийн эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт, “8.1.5 Эрүүгийн хэрэг, гомдол, мэдээлэлд прокурорын хяналтын үр ашиг сайжирч, хяналт хэрэгжүүлэх хугацаа богиноссон байх.” гэсэн заалт, “8.1.5.1 Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд прокурорын хяналт хэрэгжиж эхэлснээс яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлэх хүртэлх дундаж хугацаа. Хэмжих нэгж: Хоног, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт, “8.1.6 Прокурорын байгууллагын дотоод хяналт, сахилгын хариуцлагын тогтолцоог сайжруулах.” гэсэн заалт, “8.1.6.1 Сахилгын шийтгэл хүлээсэн прокурорын тоо, давтамж буурсан байдал. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т-10%” гэсэн дэд заалт, “8.1.7 Прокурорын байгууллагын ил тод байдал, тайлагнал, иргэдэд мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах” гэсэн заалт, “8.1.7.1 Иргэдэд нээлттэй мэдээлэл, тайлангийн хүртээмжийг дээшлүүлсэн талаар олон нийтийн санал асуулгын дүн. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “8.1.8 Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улсын стандарт, туршлагыг нутагшуулах.” гэсэн заалт, “8.1.8.1 Бүс нутгийн болон олон улсын байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, оролцсон хөтөлбөрийн тоо. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+1” гэсэн дэд заалт, “8.1.9 Прокурорын байгууллагын чадавх, хүний нөөцийн хөгжлийг бэхжүүлэх.” гэсэн заалт, “8.1.9.1 Прокуроруудын сургалт, мэргэшлийн ахицын түвшин, тасралтгүй сургалтын хамрагдалтын хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “8.1.10 Мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах.” Гэсэн дэд заалт, “8.1.10.1 Тагнуул, цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавьсан хяналтаар илэрсэн зөрчил, зөрчлийг шийдвэрлэсэн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “8.1.11 Прокурорын байгууллагын төсвийн зарцуулалт, санхүүгийн сахилга бат, үр ашгийг хангах.” гэсэн дэд заалт, “8.1.11.1 Санхүүгийн хяналтын шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоо, арилгасан зөрчлийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсамжамц нарын гишүүд.
Санал хураалт. /алх цохив/

Нийт 8 гишүүн буюу 57.1 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 1 дүгээр хавсралтын Монголын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “9.1.1.1 Судалгаанд үндэслэсэн бодлогын зөвлөгөө гаргах.” гэсэн дэд заалтыг, “9.1.1.2 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж боловсруулах.” гэсэн дэд заалтыг, “9.1.1.3 Улс орны хөгжил, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, бодлогын зөвлөгөө гаргах.” гэсэн дэд заалтыг тус тус хасах.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Үүнийгээ зөвлөлдсөн юм байгаа биз дээ. Санал хураалт. /алх цохив/

8 гишүүн буюу 57.1 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 1 дүгээр хавсралтын Монголын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “9.1.1.1 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он:"Т", Суурь түвшин:"Т", Зорилтот түвшин:"Т+10%" гэсэн дэд заалт нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Ж.Батсуурь гишүүний горимын санал. Ж.Батсуурь гишүүний микрофон.

Ж.Батсуурь: Хуруугаа уншуулж амжсангүй. Энэ санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалгаж өгнө үү.

О.Номинчимэг: Ж.Батсуурь гишүүний гаргасан горимын саналаар энэ санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт. /алх цохив/

Нийт 8 гишүүн буюу 57.1 хувь дэмжсэнээр Ж.Батсуурь гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулан өмнөх хураасан санал хүчингүй боллоо. Дахин санал хураана.

16.Төслийн 1 дүгээр хавсралтын Монголын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “9.1.1.1 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он:"Т", Суурь түвшин:"Т", Зорилтот түвшин:"Т+10%" гэсэн дэд заалт нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Гишүүд ээ, санал хураалт. /алх цохив/

9 гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Ерөнхий аудиторын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “10.1.1 Баталгаажуулах ажлын аудитыг хараат бусаар, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, журам, заавар аргачлалд 100 хувь нийцүүлэн гүйцэтгэнэ.” гэсэн заалтыг, “10.1.1.1 Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах.” гэсэн дэд заалтыг, “10.1.1.2 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийх.” гэсэн дэд заалтыг, “10.1.1.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах.” гэсэн дэд заалтыг, “10.1.1.4 Сангийн яамны 2025 оны санхүүгийн тайланд аудит хийх.” гэсэн дэд заалтыг, “10.1.1.5 Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл баталгаажуулах.” гэсэн дэд заалтыг, “10.1.1.6 Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан баталгаажуулах.” гэсэн дэд заалтыг, “10.1.1.7 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах.” гэсэн дэд заалтыг, “10.1.1.8 Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах.” гэсэн дэд заалтыг, “10.1.1.9 Гүйцэтгэх ажиллагаанд зориулсан хөрөнгийн зарцуулалтад аудит хийх.” гэсэн дэд заалтыг, “10.1.1.10 Бүх шатны төсөв захирагч, тусгай сан, төсөл, хөтөлбөр, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2026 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийх.” гэсэн дэд заалтыг, “10.1.2 Шууд тайлагнах аудитыг хараат бусаар Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, журам, заавар, аргачлалд бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ.” гэсэн заалтыг, “10.1.2.1 Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт /АДБОУС/, Төрийн аудитын байгууллагын MNS 68178, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, заавар, аргачлалыг мөрдөлт, Төсвийн байнгын хорооны тогтоолд заасан хугацаанд гүйцэтгэж, тайлагнах.” гэсэн дэд заалтыг тус тус хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд.

Далайн Батбаяр гишүүн горимын санал. Д.Батбаяр гишүүний микрофон.

Д.Батбаяр: Уучлаарай. Сая яг хуруугаа хийсэн чинь уншуулж амжсангүй. Тэгээд саяын саналыг хүчингүй болгоод дахиж санал хураалгаж өгнө үү гэсэн ийм горимын санал гаргаж байна.

О.Номинчимэг: Д.Батбаяр гишүүн техникийн асуудлаас болж энэ санал хүлээн хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалгах горимын санал гаргалаа. Горимын саналаар санал хураалт. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу 64.3 хувиар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулан түрүүн уншсан 17 дугаар саналаар санал хураалт. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Ерөнхий аудиторын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “10.1.1 Төрийн аудитын байгууллагын чанарын удирдлагын тогтолцоо олон улсын стандартад бүрэн нийцэж хэрэгждэг болно.” гэсэн заалт, “10.1.1.1 Төрийн аудитын байгууллагын чанарын удирдлагын стандарт-140 /INTOSAI-140/-н хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 50, Зорилтот түвшин: 55” гэсэн дэд заалт, “10.1.2 Төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт сайжирч, төрийн байгууллагын хариуцлагын түвшин дээшилнэ.” гэсэн заалт, “10.1.2.1 Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 79.1, Зорилтот түвшин: 80” гэсэн дэд заалт, “10.1.3 Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, дүгнэлт, зөвлөмжийн талаарх мэдээллийн ил тод байдал.” гэсэн заалт, “10.1.3.1 Нууц материалтай харилцсанаас бусад нийтэд ил аудитын тайлангаас цахим хуудсанд нийтэлсэн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: "Т", Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: "Т+10%" гэсэн дэд заалт, “10.1.3.2 Аудитын байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй тавьсан мэдээллийн хандалтын тооны өсөлтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: "Т", Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: "Т+10%" гэсэн дэд заалт, “10.1.3.3. Иргэд, байгууллагын мэдээлэл авах хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа. Хэмжих нэгж: Хоног, Суурь он: "Т", Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: "Т+10%" гэсэн дэд заалт, “10.1.3.4 Аудитын байгууллагын ил тод байдлын үнэлгээний оноо /төрийн ил тод байдлын үнэлгээний дагуу/. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: "Т", Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: "Т+10%" гэсэн дэд заалтыг тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 1 дүгээр хавсралтын Авлигатай тэмцэх газрын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “11.1.1.2 Шударга байдлын үнэлгээ. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 76.2, Зорилтот түвшин: 73.5” гэсэн дэд заалт, “11.1.1.3 Сүүлийн 12 сард төрийн албан хаагчтай харилцсан төрийн албан хаагчид авлига өгсөн иргэдийн эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 4.2, Зорилтот түвшин: 3.8” гэсэн дэд заалт, “11.1.1.4 Монгол Улсын авлигын төсөөллийн индекс. Хэмжих нэгж: Оноо, Суурь он: 2024,

Суурь түвшин: 33, Зорилтот түвшин: 43” гэсэн дэд заалт, “11.1.1.5 Олон улсын гэрээ, конвенцын болон НҮБ-ын хүний эрхийн хороодуудаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн өссөн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Хүрэх түвшин: Т+10%” гэсэн дэд заалтыг тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 8 гишүүн буюу 57.1 хувиар санал дэмжигдлээ.

20. Төслийн 1 дүгээр хавсралтын Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “12.1.8 Санхүүгийн зах зээлийн бүтцийг төрөлжүүлж, банкнаас бусад санхүүгийн салбарын хэмжээ, нөлөөллийг нэмэгдүүлэх.” гэсэн заалт, “12.1.8.1 Банкнаас бусад санхүүгийн байгууллагын хөрөнгийн хэмжээ, зах зээл дэх идэвх, оролцоог нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийн үр дүнд нийт санхүүгийн зах зээлийн бүтэц дэх эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “12.1.9 Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлж, сайжруулах арга хэмжээний үр дүнд байгууллагуудын засаглалын ил тод, хариуцлагатай байдал дээшилсэн байна.” гэсэн заалт, “12.1.9.1 Кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр “сайн” буюу түүнээс дээш үнэлгээ авсан байгууллагын эзлэх хувь нэмэгдсэн байна. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 40, Зорилтот түвшин: 60” гэсэн дэд заалтыг тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу 64.3 хувь дэмжигдсэнээр санал дэмжигдлээ.

21. Төслийн 1 дүгээр хавсралтын Төрийн албаны зөвлөлийн даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “13.1.4.4 Албан тушаалын шаардлагад нийцсэн мэргэжилтэйгээр ажиллаж буй төрийн албан хаагчдын эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “13.1.4.5 Төрийн албанд хийгдсэн хууль, журмын зөрчилтэй томилгооны тоо өмнөх оноос буурсан байна. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “13.1.9 Төрийн байгууллагууд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, ажиллах тэгш боломжийг хангана.” гэсэн заалт, “13.1.9.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулах квотыг бүрэн хэрэгжүүлж буй төрийн байгууллагын эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 10 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 1 дүгээр хавсралтын Төрийн албаны зөвлөлийн даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “13.1.8.1 дэх дэд заалтын Сургалтын хэлбэр, зохион байгуулалт, үр дүн гэснийг “Ур чадвараа дээшлүүлсэн төрийн албан хаагчийн эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: Т+10%” гэж өөрчлөх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 10 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 1 дүгээр хавсралтын Үндэсний статистикийн хорооны даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “14.1.7 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн шийдвэр гаргалтад шаардлагатай статистикийн мэдээллийн чанар, хүртээмж, бэлэн байдал сайжирч, бодлого боловсруулагчдыг найдвартай өгөгдлөөр хангах чадавх бүрдсэн байна.” гэсэн заалт, “14.1.7.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтийн мэдээллийн бэлэн байдлын түвшин. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: "Т", Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: "Т+10%" гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 10 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 1 дүгээр хавсралтын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “15.1.1.4 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод ээлтэй, саадгүй орчин бүрдүүлсэн санал өгөх байрны эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: "Т", Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “15.1.3.3. Тухайн жилд хуулийн хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлсэн улс төрийн намын тоо. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 75, Зорилтот түвшин: 90” гэсэн дэд заалт, “15.1.5 Сонгуулийн үйл ажиллагааны ил тод, шударга байдлыг хангах эрх зүйн болон байгууллагын чадавх сайжирч, Монгол Улсын чөлөөт шударга сонгуулийн индексийн түвшин нэмэгдсэн байна.” гэсэн заалт, “15.1.5.1 Чөлөөт шударга сонгуулийн индекс (Free and Fair Elections Index)-ийн оноо нэмэгдэх. Хэмжих нэгж: Оноо, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Энэ чинь одоо тэгээд оноогоор нэмэгдэнэ гээд хувиар болох юм. Суурь. Оноон дээрээ хувь юм уу. 10 хувь нь гэх юм уу. Оноо нь гэхдээ хувь биз дээ?

Тэгэхээр хэмжих нэгж чинь хувь биш үү? Окэй. Холимог юугаар болох юм байна. Тийм ээ.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 10 гишүүн буюу 71.4 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

25.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “17.2.3 Төрийн бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд жендерийн тэгш байдлын зарчмыг тусгаж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэн жендерийн тэгш бус байдлыг бууруулна.” гэсэн заалт, “17.2.3.1 ТЕЗ нарын баталсан төсөл, арга хэмжээний жендерийн үнэлгээний дундаж түвшин. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “17.2.3.2 Жендерийн тэгш бус байдлын индекс (GII)-ийн түвшин. Хэмжих нэгж: Оноо, Суурь он: 2023, Суурь түвшин: 72, Зорилтот түвшин: 79” гэсэн дэд заалт, “17.2.3.3 Төрийн болон орон нутгийн шийдвэр гаргах түвшний албан тушаалд ажиллаж буй эмэгтэй төрийн албан хаагчдын эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: “Т”, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “17.3.7 Газар эзэмшил, өмчлөл, ашиглалттай холбоотой маргаан буурч, газрын харилцааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт сайжирсан байна.” гэсэн заалт, “17.3.7.1 Шүүхээр шийдвэрлэгдэж буй нийт маргаанд газартай холбоотой маргааны эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 24, Зорилтот түвшин: 15” гэсэн дэд заалт, “17.3.8 Нутаг дэвсгэрийн ашиглалт, өөрчлөлтөд хяналт тавих хяналт-мониторингийн тогтолцоо сайжирч, хамрагдсан газар нутгийн хэмжээ нэмэгдсэн байна.” гэсэн заалт, “17.3.8.1 Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хяналт мониторингийг нэвтрүүлсэн газар нутгийн эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2025, Суурь түвшин: 24.9, Зорилтот түвшин: 32.8” гэсэн дэд заалт, “17.3.9 Орон зайн мэдээллийн стандартчилал, чанар, хэрэглээ сайжирсан байна.” гэсэн дэд заалт, “17.3.9.1 Стандартын шаардлага хангасан орон зайн мэдээллийн хэрэглээний түвшин. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2025, Суурь түвшин: 10, Зорилтот түвшин: 12” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан. Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд.

9 гишүүн дэмжиж, 64.3 хувиар санал дэмжигдлээ.

Бид 53-аас 26 дээр явж байна. Тийм үү? Тийм. 26 дугаар санал юм байна.

Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “17.1.1.1 дэх дэд заалтын Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хөрөнгийн өгөөж” гэснийг “Хэмжих нэгж:

Хувь, Суурь он: 2023, Суурь түвшин: 1.02, Зорилтот түвшин: 6” гэж, “17.1.2.1 дэх дэд заалтын Нээлттэй компани гэснийг Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2023, Суурь түвшин: 2, Зорилтот түвшин: 5” гэж, “17.3.1.1 дэх дэд заалтын Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжуулалтын нэгдсэн сангийн хаягийн мэдээллийн зөрүүг бууруулах.” гэснийг “Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжуулалтын нэгдсэн сангийн хаягийн мэдээллийн үнэн зөв, нийцтэй байдлыг сайжруулж, зөрүүний хувийг бууруулах, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: "Т", Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: "Т-10%” гэж тус тус өөрчлөх.

Энэ анхны тэр Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хөрөнгийн өгөөж гэснийг суурь түвшин нь 1.02-ыг зорилтот түвшин 6 гэдэг нь зөв үү?

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд.
Санал хураалт. /алх цохив/

Нийт есхөн гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “18.1.1.2 Хүнд суртлын индекс. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 2.85, Зорилтот түвшин: 2.95 гэх” гэсэн дэд заалт, “18.1.1.3 Экспортын бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа. Хэмжих нэгж: цаг, Суурь он: 2024, Суурь түвшин: 302, Зорилтот түвшин: 202” гэсэн дэд заалт, “18.1.1.4 Чөлөөт худалдааны хэлэлцээр. Хэмжих нэгж: тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 2, Зорилтот түвшин: 3” гэсэн дэд заалт, “18.3.1.4 дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх судалгаа, хөгжүүлэлтийн эх үүсвэр, зардлын хэмжээ. Хэмжих нэгж: хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 0.12, Зорилтот түвшин: 0.36” гэсэн дэд заалт, “18.3.1.5 h-индексстэй судлаачийн тоо. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 959, Зорилтот түвшин: 967” гэсэн дэд заалтыг тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд.
Санал хураалт. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Шадар сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “19.1.1.3 Эрт сэрэмжлүүлэх мэдээлэл дамжуулах чадамж, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 30, Зорилтот түвшин: 35” гэсэн дэд заалт, “19.2.1.2 Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий онооны дунджыг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Оноо, Суурь он: 2023, Суурь түвшин: 66.6, Зорилтот түвшин: 67.3” гэсэн дэд заалт, “19.2.1.3 Төрийн албаар үйлчлүүлсэн иргэдээс сүүлийн үйлчилгээндээ сэтгэл хангалуун байгаа иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх. (Аймаг нийслэлийн ИТХ) Хэмжих нэгж: Хувь, Суурь

он: 2024, Суурь түвшин: 12.5, Зорилтот түвшин: 20” гэсэн дэд заалт, “19.2.1.4 Төрийн албаар үйлчлүүлсэн иргэдээс сүүлийн үйлчилгээндээ сэтгэл хангалуун байгаа иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх. (Аймаг нийслэлийн ЗДТГ) Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 19.2, Зорилтот түвшин: 25.4” гэсэн дэд заалт, “19.3.1.2 Чөлөөт бүсэд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 50, Зорилтот түвшин: 60” гэсэн дэд заалт, “19.4.1.1 Нормчилсон хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 67, Зорилтот түвшин: 83” гэсэн дэд заалт, “19.4.1.2 Олон улсын менежментийн тогтолцооны ISO 9001, ISO 14001, ISO 45001, ISO 22000, НАССР стандартыг хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “19.4.1.3 Экспортын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүний төрлийн тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “19.4.1.4 Олон нийтэд үнэ төлбөргүй, ойлгомжтой хэлбэрээр хэрэглэх боломжтой болсон нэн шаардлагатай стандартын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “20.1.1.2 Зүй ёсны монопол болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчдэд хүргүүлсэн зөвлөмж, шаардлагын хэрэгжилтийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 40, Зорилтот түвшин: 45” гэсэн дэд заалт, “20.1.2.2 Хэрэглэгчийн итгэлийн индексийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Оноо, Суурь он: 2024, Суурь түвшин: 104.7, Зорилтот түвшин: 106” гэсэн дэд заалт, “20.2.1.3 Тендерт оролцогчоос захиалагчийн шийдвэрт гаргасан гомдолд үндэслэлтэй гомдлын эзлэх хувийг бууруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 22, Зорилтот түвшин: 20” гэсэн дэд заалт, “20.3.2.3 Гадаадын хөрөнгө оруулагчдын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 25, Зорилтот түвшин: 40” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Ганзоригийн Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

8 гишүүн буюу 57.1 хувиар санал дэмжигдлээ.

29. Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Шадар сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “19.4.1.2 Загварын туршилтад хамруулан улсын бүртгэлд бүртгэх, хэмжих хэрэгсэл” гэсэн дэд заалтыг, “19.4.1.3 Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах, үйл ажиллагааны чадавхаа үнэлүүлж бүртгүүлсэн аж ахуй нэг байгууллага.” гэсэн дэд заалтыг, “19.4.1.4 Шалгалт тохируулгад хамруулах хэмжих хэрэгслийн тоо” гэсэн дэд заалтыг, “19.4.1.5 Шалгалт баталгаажуулалтад заавал хамруулах хэмжих хэрэгсэл” гэсэн дэд заалтыг, “19.4.1.6 Хэмжил зүйн болон сорьцын хяналт шалгалтад хамрагдсан объект” гэсэн дэд заалтыг, “19.4.1.7 Менежментийн

тогтолцооны стандартыг нэвтрүүлж, гэрчилгээжсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ.” гэсэн дэд заалтыг, “19.4.1.8 Тохирлын үнэлгээнд хамрагдах гэрчилгээжсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ.” гэсэн дэд заалтыг, “19.4.1.9 Сорьц тогтоосон үнэт металлын хэмжээ, баталгаажуулсан эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэл.” гэсэн дэд заалтыг, “19.4.1.10 Сорьц тогтоосон үнэт металлын хэмжээ, баталгаажуулсан эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэл.” гэсэн дэд заалтыг тус тус хасах.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “21.2.1.1. MNS-ISO 9001:2016 стандартын шаардлагыг хангасан эсэх” гэснийг “MNS-ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлсэн төрийн байгууллагын эзлэх хувь /төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, нутгийн захиргаа, төрийн өмчит болон орон нутгийн өмчит байгууллагууд/, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: T+10%” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу 64.3 хувийн санал дэмжигдлээ.

31.Төслийн 1 дүгээр хавсралтын Байгаль орчин, уур амьсгалын өөрчөлтийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “22.1.3.2 Тарьсан модны амьдралтыг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 75, Зорилтот түвшин: 78” гэсэн дэд заалт, “22.4.1.2 Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний улсын дунджийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2021, Суурь түвшин: 61.9, Зорилтот түвшин: 70” гэсэн дэд заалт, “22.6.1.2 Усны чанарын индексээр маш бохир, бохир зэрэглэлтэй цэгийн тоог бууруулах. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 6, Зорилтот түвшин: 5” гэсэн дэд заалт, “22.6.1.3 Хөрсний хүнд металлын болон нянгийн бохирдол илэрсэн цэгийн тоог бууруулах. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: "Т-10%" гэсэн дэд заалт, “22.6.1.4 Дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 12, Зорилтот түвшин: 29.6” гэсэн дэд заалт, “22.6.1.5 Хот, суурин газарт тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 48, Зорилтот түвшин: 54.5” гэсэн дэд заалтыг тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд. Их чухал санал байна. Санал хураалт. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

32.Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харидцааны сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “23.1.1.4 дэх дэд заалтын Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэвлэн нийтлэх” гэснийг “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийн хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэж өөрчлөх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 10 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 1 дүгээр хавсралтын Гадаад харидцааны сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “23.1.1.5 Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын үнийн дүнд эзлэх хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “23.1.1.6 Энгийн паспортоор визгүй зорчдог улсын тоо, Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 29, Зорилтот түвшин: 30” гэсэн дэд заалт, “23.3.1.2 Урт хугацаагаар гадаадад амьдарч байгаад эх орондоо ирсэн иргэдийн тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт, “23.3.1.3 Хилийн чанад дахь монгол улсын иргэдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хариуцсан байгууллагатай 72 цагийн дотор холбогдсон хэргийн эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: “Т+10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 10 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

Ингэсэн юм байна. Гишүүд ээ. Түрүүн хуралдаан эхлэхээс өмнө Та бүхэнд би хэдэн асуудал байгаа гэж танилцууллаа. Хаана байна? Протоколын юу? 53 санал гэсэн үү? Тэгсэн энэ дээр манай энэ төсвийнхөн маань ажиллаад нэг саналыг 2 удаа бичсэнээс болоод 53 гэсэн санал болсон юм байна.

Тэгэхээр нийт санал хураалгах тоо бол 52 болж байгаа юм байна. Нэг санал хасагдаж байгаа юм байна. Тийм ээ.

34.Төслийн 1 дүгээр хавсралтын Сангийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “24.1.3 Татварын бодлогоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” гэсэн заалт, “24.1.3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохирох орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд хуулиар олгогдсон татварын хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуй нэгж байгууллага, иргэний өсөлт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: "Т", Зорилтот түвшин: "Т+5%"” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 10 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн 1 дүгээр хавсралтын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 25.1.1 дахь Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнг “Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүн төвтэй бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн амар тайван, аюулгүй байдлыг хангана” гэж, 25.4.1.3 дахь дэд заалтын “Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа” гэснийг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хэрэгжилтийн түвшин, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 10 гишүүн буюу 71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Төслийн 1 дүгээр хавсралтын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “25.1.1.7 Шинжлэх ухаанд суурилсан судалгаа, дүн шинжилгээгээр илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн нийт хэрэгт эзлэх хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “25.1.1.8 Гэмт хэрэг илрүүлэлтийн хугацааг багасгасан байдал. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Хүрэх түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “25.1.1.9 Давтамжтай дуудлага, мэдээллийн тоо буурсан байдал. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 9800, Хүрэх түвшин: 8200” гэсэн дэд заалт, “25.1.1.10 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн илрүүлэлтийн өсөлт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 60, Хүрэх түвшин: 61” гэсэн дэд заалт, “25.1.1.11 Олон улсын гэрээ, конвенцын болон НҮБ-ын хүний эрхийн хороодуудаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Хүрэх түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “25.3.5.2 Хилийн зөрчлийн илрүүлэлтийн тоог бууруулах. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 57, Зорилтот түвшин: 56”, гэсэн дэд заалт, “25.4.1.7 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг тэгш хүртээмжтэй (дохионы хэлмэрч, хадмал орчуулга зэрэг хүртээмж) олон нийтэд мэдээлсэн мэдээллийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%”, “25.4.1.8 Хүүхдэд олгох тэтгэлгийн

биелэлтийн өссөн хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+25%” гэсэн дэд заалт, “25.4.1.9 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийн дундаж хугацааны бууралт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “25.4.1.10 Олон улсын гэрээ, конвенцын болон НҮБ-ын хүний эрхийн хороодуудаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “25.4.1.11 Гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол төлбөр барагдуулалтын гүйцэтгэл. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 84.1, Хүрэх түвшин: 85” гэсэн дэд заалтыг тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 11 гишүүн буюу 78.6 хувиар санал дэмжигдлээ.

37.Төслийн 1 дүгээр хавсралтын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 25.6.1 дэх заалтыг бүхэлд нь, 25.8 дахь хэсгийг бүхэлд нь тус тус хасах.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 11 гишүүн буюу 78.6 хувиар санал дэмжигдлээ.

38.Төслийн 1 дүгээр хавсралтын Зам, тээврийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 26.1.1.1 дэх дэд заалтын “Авто тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоонд хамрагдалт” гэснийг “Авто тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоонд хамрагдалтыг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2025, Суурь түвшин: 75, Зорилтот түвшин: 90” гэж өөрчлөх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн буюу 78.6 хувиар санал дэмжигдлээ.

39.Төслийн 1 дүгээр хавсралтын Батлан хамгаалахын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “27.1.1.2 Оюутан цэрэгт хамрагдсан оюутны тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “27.1.1.3 Цэргийн алба хааж байх хугацаандаа мэргэжлийн үнэмлэх эзэмшсэн иргэдийн хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “27.1.1.4 Цэргийн алба хаах насанд хүрсэн иргэдийн дундаас алба

хаасан иргэдийн хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд. Санал. Хураалт. /алх цохив/

11 гишүүн буюу 78.6 хувиар санал дэмжигдлээ.

40.Төслийн 1 дүгээр хавсралтын Боловсролын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “28.1.1.5 Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан цэцэрлэгийн эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 72.2, Зорилтот түвшин: 77.76” гэсэн дэд заалт, “28.2.1.7 3 ээлжээр хичээллэж буй сургуулийн тоог бууруулах. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 8, Зорилтот түвшин: 4” гэсэн дэд заалт, “28.2.1.8 Секц, дугуйлан, спортод хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “28.2.1.9 Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувийг нэмэгдүүлэх /Нийслэл/. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 75.2, Зорилтот түвшин: 85.2” гэсэн дэд заалт, “28.2.1.10 Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувийг нэмэгдүүлэх /Аймаг/. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 96.6, Зорилтот түвшин: 98” гэсэн дэд заалт, “28.2.1.11 Барилгын стандартыг хангасан сургуулийн дотуур байрны эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 63, Зорилтот түвшин: 73” гэсэн дэд заалт, “28.2.1.12 Дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг сайжруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “28.3.1.6 Багш мэргэжлээр төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “28.5.1.3 Насан туршийн суралцахуйн төвд хамрагдах шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн буюу 78.6 хувиар санал дэмжигдлээ.

41.Төслийн 1 дүгээр хавсралтын Боловсролын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 28.2.1.4 дэх дэд заалтын “Мэргэжлийн багшаар хангагдсан сургууль” гэснийг “Багшаар бүрэн хангагдсан төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 53, Зорилтот түвшин: 53.5” гэж, 28.4.1.2 дахь дэд заалтын

“КООСЭН хөтөлбөр хэрэгжүүлж буй политехник коллежууд” гэснийг “КООСЭН хөтөлбөр хэрэгжүүлж буй политехник коллежийн тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 3, Зорилтот түвшин: 5” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

Нийт 12 гишүүн буюу 85.7 хувиар санал дэмжигдлээ.

42.Төслийн 1 дүгээр хавсралтын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “29.1.5.2 Боловсруулах аж үйлдвэрүүдийн түүхий эдийн тасралтгүй хангалтын түвшинг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн буюу 85.7 хувиар санал дэмжигдлээ.

43.Төслийн 1 дүгээр хавсралтын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 30.1.3.2 дахь дэд заалтын “Мах, сүү, мах-сүүний өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн үхрийн тооны өсөлт” гэснийг “Мах, сүү, мах-сүүний өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн үхрийн эзлэх хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэж өөрчлөх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн буюу 85.7 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 1 дүгээр хавсралтын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “30.1.1.2 Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тэжээл (кг), Суурь он: 2024, Суурь түвшин: 8, Зорилтот түвшин: 9” гэсэн дэд заалт, “30.1.3.3 Нийт малын тоонд өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 5.3, Зорилтот түвшин: 7” гэсэн дэд заалт, “30.1.3.4 Мал аж ахуй эрхлэгчдийн голч орлогын өсөлтийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “30.2.1.5 Малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “30.6.1.4 Жижиг, дунд үйлдвэрийг

дэмжих зээлд хамрагдсан аж ахуйн нэгжийн борлуулалтын өсөлт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+8%” гэсэн дэд заалт, “30.7.1.3 Санхүүгийн дэмжлэг авсан хоршоодын борлуулалтын өсөлт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+8%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн буюу 85.7 хувиар санал дэмжигдлээ.

45.Төслийн 1 дүгээр хавсралтын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 31.2.1.1 дэх дэд заалтын “Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг бүсүүдийн амьжиргааны доод түвшний дундажтай харьцуулсан харьцаа” гэснийг “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн дундаж болон амьжиргааны түвшний харьцаа, бүсээр. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2023, Суурь түвшин: 0.8, Зорилтот түвшин: 0.82” гэж, 31.2.1.2 дахь дэд заалтын “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг чадавхжуулж, орлого нэмэгдүүлэх хөтөлбөр, үйлчилгээнд хамруулсан өрх” гэснийг “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг чадавхжуулж, орлого нэмэгдүүлэх хөтөлбөр, үйлчилгээнд хамруулсан өрх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 1259, Зорилтот түвшин: 3000” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн буюу 85.7 хувиар санал дэмжигдлээ.

46.Төслийн 1 дүгээр хавсралтын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “31.1.1.4 Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийн жилийн дундаж өгөөжийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “31.2.1.3 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуурх өрхийн бууралт. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “31.3.1.4 Албан бус ажил эрхлэлтийн нийт ажил эрхлэлтэд эзлэх хувийг бууруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2023, Суурь түвшин: 44.8, Зорилтот түвшин: 44” гэсэн дэд заалт, “31.3.1.5 Нийт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдсан иргэдийн дундаас нийгмийн даатгалын шимтгэлийг 6 сараас дээш хугацаанд төлж байгаа иргэдийн хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 43.1, Зорилтот түвшин: 47” гэсэн дэд заалт, “31.3.1.6 Суралцаагүй, хөдөлмөр эрхлээгүй эсвэл сургалтад хамрагдаагүй 15-24

насны залуучуудын тухайн насны хүн амд эзлэх хувийг бууруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 10.1, Зорилтот түвшин: 9.6” гэсэн дэд заалт, “31.3.1.7 Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настныг асарч байгаа иргэний хөдөлмөр эрхлэлтийн хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “31.3.1.8 Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргааны тоог бууруулах. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 770, Зорилтот түвшин: 695” гэсэн дэд заалт, “31.5.2.2 Хүүхэд хүчирхийлэлд өртөх эрсдлийг бууруулах. Хэмжих нэгж: Эрсдлийн үнэлгээ, Суурь он: Т, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10% бууралт” гэсэн дэд заалт, “31.5.2.3 Хүүхдийн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хувийг бууруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: Т, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

12 гишүүн буюу 85.7 хувиар санал дэмжигдлээ.

47.Төслийн 1 дүгээр хавсралтын Эрүүл мэндийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “32.1.2 Чихрийн шижин өвчний тархалт буурч, хүн амын дунд эрүүл хооллолт, хөдөлгөөний идэвх нэмэгдэнэ.” гэсэн дэд заалт, “32.1.2.1 Архаг эмгэгийн дундаас чихрийн шижингийн тархалтыг бууруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-5%” гэсэн дэд заалт, “32.1.3 Тамхины хэрэглээ буурч, уушги, зүрх судасны өвчний шалтгаант нас баралт, өвчлөл буурна.” гэсэн дэд заалт, “32.1.3.1 Өдөр бүр тамхи татдаг хүмүүсийн эзлэх хувийг бууруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-5%” гэсэн дэд заалт, “32.1.4 Архи, согтууруулах ундааны хэрэглээний бууралтаар эрүүл мэндийн хохирол, осол гэмтэл, нийгмийн сөрөг нөлөө буурна.” гэсэн дэд заалт, “32.1.4.1 Нэг хүнд ногдох архины хэрэглээг бууруулах. Хэмжих нэгж: Литр, Суурь он: 2024, Суурь түвшин: 21.9, Зорилтот түвшин: 21” гэсэн дэд заалт, “32.1.5 Эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөн төлөвшин, таргалалт, зүрх судас болон чихрийн шижингийн эрсдэл буурна.” гэсэн дэд заалт, “32.1.5.1 Таргалалтын түвшинг бууруулах (Биеийн жингийн индекс ≥ 30). Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-5%” гэсэн дэд заалт, “32.1.6 Чихрийн шижингийн эрт илрүүлэлт, оношлогоо, хяналт сайжирч, хүн амын дунд өвчлөлийг бууруулах нөхцөл бүрдэнэ.” гэсэн дэд заалт, “32.1.6.1 Артерийн даралт 140/90 мм.муб-аас дээш, цусан дахь глюкозыг нь хэмжсэн хүмүүсийн дунд чихрийн шижингийн илрүүлэлтийн түвшинг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “32.2.6 Хорт хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналтын үр дүн дээшлүүлэх” гэсэн дэд заалт, “32.2.6.1 Хорт хавдраар оношлогдож, эмчлэгдсэнээс хойш 5-аас дээш жил амьдарсан иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 42.7, Зорилтот түвшин: 45.0” гэсэн дэд заалт, “32.4.2 Эрүүл мэндийн

тусламж, үйлчилгээний тогтолцоонд анхан шатны тусламж, урьдчилан сэргийлэх үйлчилгээний үүрэг, санхүүжилт нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийн чанар, хүртээмжийг сайжруулах” гэсэн дэд заалт, “32.4.2.1 Эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээнд зарцуулж буй нийт зардалд анхан шатны тусламж, үйлчилгээний зарцуулалтын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “32.4.3 Эрүүл мэндийн даатгалын хамралт өргөжиж, шимтгэлээ өөрөө төлөгч иргэдийн тоо нэмэгдэж, даатгалын сангийн тогтвортой байдал, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.” гэсэн дэд заалт, “32.4.3.1 Шимтгэлээ өөрөө хариуцдаг иргэдийн хамралтыг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+10%” гэсэн дэд заалт, “32.4.4 Иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн дарамт буурч, санхүүгийн хамгаалалт сайжирна.” гэсэн дэд заалт, “32.4.4.1 Эрүүл мэндийн урсгал зардалд иргэдийн хувиасаа хийж буй төлбөрийн хувь хэмжээг бууруулах. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн буюу 78.6 хувиар санал дэмжигдлээ.

48.Төслийн 1 дүгээр хавсралтын Эрчим хүчний сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 33.1.2.1 дэх дэд заалтын “км” гэснийг, Хэмжих нэгж: “МВт” гэх, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэж өөрчлөх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

11 буюу 78.6 хувиар санал дэмжигдлээ.

49.Төслийн 1 дүгээр хавсралтын Эрчим хүчний сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “33.1.5.2 Хот суурин газрын агаарын бохирдлын бууралт, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-5%” гэсэн дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нарын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн буюу 78.6 хувиар санал дэмжигдлээ.

Гишүүд ээ, 50 дугаар санал. Одоо гуравхан санал байна.

Төслийн 1 дүгээр хавсралтын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 34.1.3.1 “Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээ” гэснийг “Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 83.6%, Зорилтот түвшин: 85%” гэж, 34.1.4.1 “Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам сүлжээ” гэснийг “Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 69.6%, Зорилтот түвшин: 70%” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

51.Төслийн 1 дүгээр хавсралтын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “34.1.5.3 Түрээсийн орон сууцанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “34.1.5.4 Түрээсийн орон сууцанд хамрагдсан өрхийн хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “34.1.1.2 Барилгын зураг төслийн магадлан, барилгын ажлын улсын комисст зарцуулах голч хугацаа буурах хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “34.1.1.3 Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ шинээр авч буй барилгад эзлэх ногоон барилгын шалгуур хангасан барилгын эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 1, Зорилтот түвшин: 10” гэсэн дэд заалт, “34.1.1.4 Олон нийтийн барилгын орц гарцыг түгээмэл загвараар шийдсэн барилгын хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 11, Зорилтот түвшин: 21” гэсэн дэд заалт, “34.1.5.5 70%-аас дээш эрчим хүчний хэмнэлттэй болгон дулаалсан сууцны нийт сууцанд эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 7, Зорилтот түвшин: 17” гэсэн дэд заалт, “34.3.5.4 Нийт барилга байгууламжийн дундах галын дохиололтой барилгын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн буюу 78.6 хувиар санал дэмжигдлээ.

Сүүлийн Санал хураалт. Гишүүд ээ.

52.Төслийн 1 дүгээр хавсралтын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “35.1.1.2 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн нийт экспортод эзлэх хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+1%” гэсэн дэд заалт, “35.1.1.3 Үндэсний агуулгатай уран бүтээлийн тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 2500, Зорилтот түвшин: 2550” гэсэн дэд заалт, “35.1.1.4 Авран хамгаалсан соёлын биет өвийн тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 15, Зорилтот түвшин: 30” гэсэн дэд заалт, “35.1.1.5 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 10924, Зорилтот түвшин: 10974” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Г.Лувсанжамц нарын Улсын Их Хурлын гишүүд. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн буюу нийт 78.6 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Өргөдлийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Төсвийн Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Өргөдлийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Бас тэвчээртэй байж санал хураалтдаа идэвхтэй оролцсон Байнгын хорооны гишүүддээ талархъя.

Байнгын хорооны хуралдааныг хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 3 цаг 16 минут үргэлжилж, 14 цаг 41 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД